



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-10
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	11-51

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	2-19
2.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	19-44
3.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	44-45
4.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	46
5.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	47
6.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	47-48
7.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	48
8.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай санал /Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн 2026.05.21-ний өдөр Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн/	48-50
9.“Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	50-51

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 10-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 14 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Батшугар;
Чөлөөтэй: Х.Баттулга, Б.Дэлгэрсайхан.

Нэг.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Э.Дарханцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, О.Номинчимэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Батлут нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн шалгах албаны Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга Д.Сайнжаргал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Э.Оюунтунгалаг, Ө.Өнөрлхам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Л.Соронзонболд, С.Одонтуяа, Д.Пүрэвдаваа, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал 15 цаг 20 минутаас 15 цаг 40 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Б.Баярбаатар, Б.Тулга, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 11
Бүгд: 24
54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Д.Цогтбаатар: 2.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 12
Бүгд: 24
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

5.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, С.Одонтуяа нарыг нэмж оруулъя гэсэн санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 11
Бүгд: 24
54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 11
Бүгд: 24
54.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, О.Номинчимэг, Х.Баасанжаргал, П.Сайнзориг, С.Одонтуяа, С.Эрдэнэболд нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24

62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Тэмүүжин нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24

62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа, С.Цэнгүүн нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 10

Бүгд: 24

58.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Ц.Сандаг-Очир нарыг хасахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 8

Бүгд: 24

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай санал /Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн 2026.05.21-ний өдөр Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн саналыг танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчиж байгаа талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	10
Бүгд:	24

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Ес. “Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	11

Бүгд: 24
54.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 10 минут үргэлжилж, 28 гишүүнээс 25 гишүүн хүрэлцэн ирж, 89.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 14 цаг 14 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, ирсэн гишүүд Оюунсайханы Алтангэрэл, Дамбын Батлут, Баярмагнайн Баярбаатар, Лхагвын Мөнхбаатар, Мөнхтөрийн Нарантуяа, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Буяагийн Тулга, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц 67.9 хувиар бүрдэж хурал эхэлж байна гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя аа.

Хэлэлцэх асуудал өнөөдөр 9 асуудал байна.

Нэгдүгээр асуудал, Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 37 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал байгаа.

Хоёрдугаар асуудал, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 37 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх байгаа.

Гуравдугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”.

Дөрөвдүгээр асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”.

Тавдугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”

Зургаадугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”,

Долоодугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Цаглавар батлах тухай”,

Наймдугаар асуудал, ҮХЦ-д хүсэлт гаргах саналын тухай,

Есдүгээр асуудал бусад гэсэн ийм дэс дараатай агуулгатай хэлэлцэх асуудлууд байна аа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байвал нэрсээ өгнө үү? Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа ороод явцгаая.

Хэлэлцэх асуудлаа хэлэлцэж эхэлье.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяад танилцуулна аа. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Эрхэм Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцын хэрэгжилтийг хангах, цэргийн байгууллага дахь хүний эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлээд байна аа. Хуулийн төслөөр Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь хэсэгт нэмэлт оруулж эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэс үндэсний ажиллагааны чиг үүргийн хүрээнд цэргийн алба хаагчдад зориулсан сургалт, соён, гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр тусгасан.

Монгол Улсын ХЭҮК нь хүний эрхийг хамгаалах сурталчлах чиг үүрэг хэрэгжүүлдэг боловч цэргийн байгууллагад чиглэсэн тусгайлан сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалт өнөөдөр хангалтгүй байна аа. Үүний улмаас цэргийн алба хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг тогтмол нэмэгдүүлэх, эрсдэлийг урьдчилан илрүүлэх, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх ажил системтэй хэрэгжих боломж хязгаарлагдмал хэвээр байна. Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагуудаас Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдэд цэргийн байгууллага дахь хүний эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх эрүүдэн шүүх болон хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэхийг онцлон зөвлөсөн.

Тухайлбал НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжид цэргийн алба хаагчдад холбогдох гомдлыг үр нөлөөтэй шалгах, урьдчилан сэргийлэх механизмын хяналтыг сайжруулах шаардлагыг дурдсан байдаг аа. Цэргийн байгууллага нь хаалттай орчинд үйл ажиллагаа явуулдаг онцлогтой. Ийм нөхцөлд дүрмийн бус харьцаа, сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл зэрэг хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга замын нэг нь хүний эрхийн боловсрол соёлыг тогтолцоотой төлөвшүүлэх явдал юм аа. Хуулийн төсөл батлагдсанаар цэргийн алба хаагчдад зориулсан хүний эрхийн сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах эрх зүйн үндэс бүрдэх бөгөөд алба хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Үүний үр дүнд дүрмийн бус харьцаа, дарамт шахалт, хүчирхийлэл зэрэг хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл сайжирч хүний эрхийг хүндэтгэсэн байгууллагын соёл төлөвшихөд эерэг нөлөө үзүүлнэ ээ.

Түүнчлэн захирагч удирдах бүрэлдэхүүн хүний эрхэд суурилсан удирдлагын арга барилыг төлөвшүүлж сахилга хариуцлагыг дарамт шахалт бус харилцан хүндэтгэл ойлголцолд тулгуурлан хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм аа.

Мөн хүний эрхийн зөрчлийг эрт илрүүлэх, мэдээлэх, шийдвэрлэх тогтолцоо бэхжиж, дотоод хяналтын үр нөлөө нэмэгдэнэ ээ. Улмаар цэргийн байгууллагад хүний эрхийг дээдэлсэн, сахилга хариуцлагатай, харилцан хүндэтгэлтэй орчин төлөвшиж алба хаагчдын аюулгүй байдал, сэтгэл зүйн тогтвортой байдал ажлын бүтээмж сайжрахын зэрэгцээ цэргийн албаны нэр хүнд олон нийтийн итгэл нэмэгдэх ач холбогдолтой гэж үзэж байна аа. Түүнчлэн энэхүү хуулийн төсөл нь улсын төсөвт нэмэлт ачаалал төдийлөн үүсэхгүй бөгөөд асуудал хариуцсан байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хэрэгжих юм аа.

Иймд Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүнд баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Номинчимэг гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Одонтуяа гишүүнээс асуух асуулт байна. Энэ цэргийн анги энэ цэргийн байгууллагууд дээр болоод байгаа юм чинь дарга нарт нь биш очсон хүмүүсээ зодчихоод байгаа биз дээ. Тэгэхээр энэ дээр бичигдсэнээр цэргийн алба хаагчдад зориулсан хүний эрхийн сургалт соён гэгээрүүлэх үйл ажиллагаа гээд ингээд байна л даа. Тэр зодоод байгаа дарга нарт нь тэр атамандаад байгаа нөхдүүдэд нь хариуцлага тооцдог тал дээр тэр ч бараг сургалт яваад ч нэмэргүй шахуу байх даа. Тэр очсон нөхдүүдэд яах вэ сургалт явуулж болох байх. Тэр чинь богинохон хугацаанд очоод явчхаж байгаа шүү дээ.

Үгүй тэрний цаана нь үлдэж байгаад л хүний аминд хүртэл юм хийж байгаа энэ хүмүүс дээр яах юм. Одоо таны энэ дээр бичсэнээр бол ингээд байх юм. Захирагч, удирдах бүрэлдэхүүн хүний эрхэд суурилсан удирдлагын арга барил үгүй тэр ном заагаад төлөвших үү? Та нэг энэ дээр ер нь ямархуу бодолтой байна хэлээч? Би ер нь дэмжье гэж бодож байна. Тэгэхдээ яг бай чинь таны та бидний хүсэж байгаа бай яг онож байна уу, үгүй байна уу? Энийг ер нь яаж шийдэх вэ? Дахиад нэг нэмэлт юм байгаа, асуучхаж болох билүү? Тэгье.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя аа. Ер нь энэ цэргийн алба хаагчдад гэдэг дотор алба хааж байгаа хүмүүс, удирдах бүрэлдэхүүн бүгд бол орох юм. Бүх хүмүүст энэ сургалт явагдана гэсэн үг.

Тэгэхээр таны хэлж байгаа болгоомжлол зөвхөн тэр дарга нараас бусад хүмүүст явбал үр дүнгүй юм биш үү гэдэг асуудал гарахгүй. Бүх удирдах бүрэлдэхүүн цэргийн алба хаагчдад бүгдэд нь сургалт хийнэ. Ингэснээр энэ хүмүүст яг энэ ер нь эрүүдэн шүүх гэдэг чинь юуг хэлдэг юм бэ? Зөвхөн зодож жанчихаас гадна хүний нэр төрд халдах, өвлийн хүйтэнд удаан зогсоох, хоол ундгүй байлгах, гутаан доромжилж харьцах гээд энэ бүх зүйлийг яг ийм шинжлэх ухааны үндэслэлтэй гэдэг юм уу ингэж заана. Энийг зөрчсөн хүмүүст ямар ямар эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг юм? Ер нь хүний эрхийн зөрчлийг хэрхэн бид нар дээдлэх ёстой юм гэдэг энэ бүх зүйлүүд яг энэ олон улсын нэгдэн орсон конвенцын, тэр загварын дагуу ер нь хийгдэнэ.

Дээрээс нь Монгол Улсын хэмжээнд байгаа бүх цэргийн анги нэгтгэлүүдээр энэ ингээд хийгдээд явах юм аа.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Яг энэ асуудал биш. Тэгэхдээ энэ хууль чинь болохоор Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гээд. Тэгээд сая тэр хүний эрхийн комиссын нөхдүүд маань хууль зөрчөөд. Одоо Хүний эрхээ хамгаалах нэг хэдхэн нөхөр байгаа шүү дээ. Тэгээд тэд нар маань хууль зөрчөөд дарга нартаа далдганаад ингээд сууж байгаа юмыг хэдүүлээ дуудаж ирээд огцруулдаг барьдаг хууль байгаа билүү. Мэдэхгүй байна. Энэ ер нь нэг жаахан хариуцлага тооцохгүй бол. Тэгсэн гэнэ үү цаадах чинь нэг тийм бичиг өгчихсөн гэнэ үү гээд л нэг ийм ойр зуурын яриа болгоод өнгөрөөгөөд байдгийг болимоор байх юм аа. Тэр чинь бол Монгол Улсад асар том хариуцлага хүлээж байгаа манай Хууль зүйн байнгын хорооны өмнө ялангуяа том хариуцлага хүлээж байгаа хүмүүс шүү дээ. Тэгээд л сэтгүүлчдийн эрхэд халдаад л дарга нартаа үйлчлээд суугаад байдаг байж болмооргүй байна. Нэр устай нь хэлээд юу байна уу? Золжаргал зөвлөх өө.

Д.Цогтбаатар: Ер нь дарга ийм байгаа. Тиймэрхүү алдаатай бол ийм ХЗБХ миний авсан мэдээллээр, тэр өгсөн тайлбаруудаас би харахад тэр нээрээ алдаатай л үйлдэл хийсэн байна лээ. Тийм юмтай Байнгын хороод эвлэрч сууж болохгүй. Энэ дээр бид нар асуудлыг нь гаргаж яриад энэ иймэрхүү байдлаар хүний эрх хамгаална гэдэг. Энд чинь бид нар өчнөөн процесс болж эд нарыг томилоод явуулж хуулийг нь батлаад өгөөд явуулж байхад ийм юм хийгээд суугаад байна гэж ойлголт байж болохгүй. Би энэ дээр өшөө нэмээд яг нөхцөл байдлыг нь тодруулж юмнуудыг нь авъя гээд яагаад гэвэл хуулийн асуудал болохоор тэгж байгаа. Гэхдээ үнэхээр юу гэдэг юм тэр биометрийн мэдээллийг өгсөн байна гээд юу гэнэ вэ торгочихсон тийм утгагүй тэгээд тэр нь профайл байгаа бол энэ шууд өөрөө илт нөгөө нарийвчилж судлаад ч хэрэггүй, аягүй тодорхой буруу асуудал шинжтэй харагдаж байна лээ. Тэрийг нь бол би өшөө нарийвчилж судлаад үзье. Тийм яг үнэн.

Тэгэхээр Байнгын хорооны гишүүд ч гэсэн та нар маань энд ингээд хүний эрхийн ийм асуудлыг гаргаж ирж тавьж байгаа чинь өөрөө тэнд очиж байгаа хатуу мессеж байхгүй юу. Бид нар ийм юмыг бол тэвчээд суугаад байхгүй гэдэг юуг Байнгын хороо өгч байх ёстой. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр Монгол Улс энэ эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх энэ нэмэлт протоколд 2014 онд элссэн юм байна лээ. Ер нь энэ ХЭҮК-ын энэ хуулийн гол ач холбогдол юу вэ гэхээр манай гишүүд нэг зүйлийг мэдэх ёстой.

Эрүүдэн шүүхийн ажиллагаа бол ер нь голдуу л ар талдаа нэг том артай хүмүүс энэ эрүүдэн шүүхийг хийгээд байх шиг байгаа юм.

Тэгэхээр аль болохоор энэ байгууллага бол хараат бус байна гэдэг ийм зүйлийг бол ерөөсөө гол конвенцын гол амин сүнс нь байгаа юм. Гэхдээ манайд байгаа ХЭҮК болон эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа 2 дотор нэг бид нар статусыг нь энэ Байнгын хороо, Их Хурлаараа ярьж нэг жоохон тодорхой болгож зааг юунуудыг нь гаргаж өгмөөр юм байна лээ. Тэгэхгүй бол энэ дандаа маргаантай байдаг. Манайх энийгээ шийднэ. Энэ ингээд тусдаа байх ёстой. Дарга нь энийг шийднэ.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ бол ерөөсөө л энэ бие даасан хараат бус байна гэдэг нь гол юм нь байгаа. Энэ хуульд яагаад орох болсон юм бэ гэхээр Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор энэ цэргийн анги нэгтгэлийн тоо, байршил, бүрэлдэхүүн энэ зүйлүүд энэ нөгөө нууцын жагсаалтаар зохицуулагддаг тэгэхээр өмнө нь ийшээ шууд ороод энэ үндэсний ажиллагааг явуулах боломжгүй байсан. Одоо энийг баталчих юм бол бид нар энэ үндэсний ажиллагааг эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг тэнд хийх боломж нь хуулиар ингээд нээгдэж өгөх юм аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Баярлалаа. Энэ хуулийн төсөл яах вэ би бас нөгөө дэмжиж гарын үсэг зурсан гишүүдийн нэг.

Тэгэхээр хуулийн төсөлтэй холбоотой асуулт гэхээсээ илүү нэг юм хэлмээр санагдаж байгаа. Одоо энэ өчигдөр ч гэсэн нэлээн асуудал болоод байгаа Хүний эрхийн Комисс дээр өөрсдөө хүний эрхийн ямар ч мэдрэмжгүй хууль тогтоомжийг гуйвуулж хэрэглэдэг харваас үзвээс ийм асуудал дээр ингэж хууль дээдлэх ёсыг баримталдаггүй асуудлаас Хүний эрхийн Комисс нь ингэж ажиллаж байгаагаас болоод хүний эрх зөрчигдөж байгаа асуудал хөндөгдөж байгаа. Тэгээд бид нар энэн дээр их анхаарах ёстой.

Дээр нь манай Өргөдлийн байнгын хороон дээр бүр тэр бол яах вэ нэг албаны даргын, хэлтсийн даргын түвшинд байсан Хүний эрхийн Комиссын гишүүний статустай хүнтэй холбоотой ийм маргаанууд ирж байгаа. Яг л хүний хувийн мэдээллийг хууль бусаар задруулж байгаа, хүний халдашгүй эрхэд халдаж байгаа нь тогтоогдоод байхад энийг нийтэд зарлаж байгаа гээд ийм өргөдлүүд ирж байгаа. Тэгэхдээ яах вэ манайд Хүний эрхийн дэд хороонд энэ өргөдлийг ирэнгүүт манайх руу шилжүүлчихдэг байхгүй юу. Өргөдөл юмыг чинь май гээд. Тэгээд энэ асуудлыг нь бид нар Төрийн албаны зөвлөл дээр та хэд шалгах уу гэхээр бид нар төрийн өндөр албан тушаалтныг шалгах эрхгүй байна аа. Энэ асуудлыг гээд ингэчихдэг.

Энийгээ бид нар яахгүй бид нар чинь ХЭҮК-ын гишүүд чинь өөрсдөө гишүүдийнх нь шийдвэр эцсийн байдаг, тэрийг нь нэг их хянаж үздэггүй Улсын Их Хуралд энэ чинь хүний эрхийг хангах талаар хамгийн хүчтэй зөвлөн тусалж байх ийм институт байтал тэр гишүүд нь өөрсдөө хүний эрхийн ийм зөрчил ялангуяа тэр хүний хувийн мэдээллийг задруулдаг, халдашгүй байдалд халддаг гэдэг ийм асуудал гаргах юм бол бид нар ямар арга хэмжээ авч байх юм? Энийгээ яаж

хэлэлцэж тэр хүмүүстэй хариуцлага тооцох юм гэдэг юмаа бид нар харахгүй бол Хүний эрхийн Комисс бол ийм анхан шатын хүний эрхийн мэдрэмжгүй ийм шийдвэрүүд гарч байгаад бол мэдээж дотроо хариуцлагаа тооцох гээд ярьж байгаа байх. Гишүүдийн түвшинд буюу хамгийн дээр байдаг комиссын гишүүдийн түвшинд, эсвэл гишүүний статустай тэр хүмүүстэйгээ бид нар яаж ярих юм гэдэг асуудлыг Хууль зүйн байнгын хороо нэг тодорхой болгож өгмөөр байна.

Би энэ 3 сард ирсэн өргөдлийг Хүний эрхийн дэд хороо над руу явуулчихсан. Дэд хороон дээрээ эсвэл буцаагаад ярих ёстой юм уу? Эсвэл ХЗБХ-н дээрээ тавиад бид нар энэ асуудлыг судлах ёстой юм уу? Тийм нэг асуудал байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Зөв манай дээр ирээд бид нар яг судлаад Байнгын хороо судлаад явж байгаа. Хэдүүлээ тэгэхлээр яг энэ дээр цуглаад тийм нэгтгээд тал талаасаа хараад явъя. Зүгээр Хүний эрхийн Комиссын нэг асуудал байгаа. Бид нар бүр цаанаасаа нөгөө энэ чинь хараат бус байлгах гэж хуулиа баталж өгсөн учраас амьдрал юм чинь тэгээд алдаа гарч байна шүү дээ. Гэхдээ Хүний эрхийн Комиссын гишүүнийг Их Хурал дээр эргүүлээд татах юм уу ийм асуудлууд тэр чинь нөгөө хараат бус байдлыг нь хангаж өгөхгүй. Энэ бол аягүй хязгаарлагдмал асуудал байж байгаа. Бид нар тийм учраас би сая Алтанхуяг гишүүнийг яг бид нар ингээд шүүмжлээд ийм юмыг тэвчихгүй шүү гэдэг асуудлаа шууд гаргаад тавьж байх ёстой. Энэ дээр тэгээд би бүүр материалуудыг нь харин бүүр татаж үзье гээд. Сая тэр дуулдсан мэдээлэл би өөрөө гайхаж байгаа байхгүй юу. Бас арай зарим юм чинь нэг ойлгомжгүй байдаг. Тэр бол дэндүү л ойлгомжтой юм шиг надад санагдсан. Тэгээд тэрийг нь хэдүүлээ аваад энэ дээрээ ярья.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд энэ дээр үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Одонтуяа гишүүний энэ санаачилж байгаа хуулийг зарчмын хувьд дэмжиж байна аа. Уг нь бол одоо хуулийн асуудал гэхээсээ илүү батлан хамгаалах салбарын дүрэм журмын хэмжээнд хязгаарлаад л ийм зүйлүүд дээрээ ойлголцол хийж чадахгүй байсан болов уу гэж бодоод байгаа юм. Тэгээд ямар ч байсан ингээд тодруулаад өгчих нь нэг талдаа зөв байх.

Хоёрдугаарт ХЭҮК-ын энэ эрүүдэн шүүхийн механизмын асуудлыг зөв ажиллуулах энэ урьдчилан сэргийлэх механизм байхгүй юу, урьдчилан сэргийлэх. Түүнээс биш та хэд ингээд давхацсан хяналт шалгалт хийдэг байгууллага биш юм байгаа юм. Урьдчилсан механизм учраас энийг Хууль зүйн яамны дэргэд ч байгуулж болно гэж ярьж байсан. Тэгээд уг нь ингээд комисс дотроо яасан ингээд салж нийлж тоглодог. Иймэрхүү зүйлээсээ татгалзаад энэ хуулиа зөв зохистой хэрэгжүүлэх хуулийн байгууллагуудыг комиссын гишүүдтэйгээ зэрэгцэж орж давхцуулж хяналт шалгалт хийж дарамталдгаа болих хэрэгтэй. Тэгээд нөгөөдүүл нь ярьж чаддаггүй комиссарууд учраас. Яг үнэндээ хэлэхэд одоо манай энэ комиссар болоод тэгээд хуулийн байгууллагуудаас нь дотоод алба хаагчдаа дарамталдаг. Нөгөө комиссынхонтой уулзсан хүмүүсдээ арга хэмжээ авдаг, халдаг ийм бүүр байгаа муухай соёлтой байгууллага болгоод тавьчихсан. Тэгээд би энэ дээр жоохон харамсаад байгаа юм. Ямар ч байсан тэгээд энэ байгууллагыг мэдээж хүнд нь тааруулж хэдүүлээ байлгана байлгахгүй гэж хэлж болохгүй. Сайжруулаад явах ёстой хүнийх нь хугацаа ч гэсэн удахгүй дуусах байх. Тэгээд маш зөв зохистой бас

энийг ойлгодог хүн тавихгүй бол олон улсын гэрээ конвенцыг буруу тайлбарладаг, баталсан хуулийг буруу тайлбарлаж ойлгож хэрэгжүүлдэг хүмүүс энийг ажиллуулж чадахгүй юм байна гэдэг зүгээр харагдаж байна лээ.

Хоёрдугаарт, энэ ХЭҮК-ын бас энэ хариуцлагагүй үйл ажиллагаа сая гарлаа. Түрүү 7 хоногт л бид нар 25 дахь илтгэлийг маш сайн болжээ. Мундаг байна. Гэтэл доогуур нь байгаа нэг одоо дунд түвшний албан хаагчаас болоод л хэвлэл мэдээллийн эрх чөлөө үзэл бодлоо илэрхийлж байгаа эрх чөлөө хуульд байгаа зохицуулалтыг мушгиж тайлбарлаж хүний эрхийг зөрчих үйлдлийг өөрөө ХЭҮК гаргалаа. Тэгээд комисс Монгол Улсын Ерөнхий сайд болон Улсын Их Хурлын даргыг улалзуулж тэр хүмүүс мэдэгдэл гаргах хэмжээнд ингэж байхаар өөрсдөө гараад уучлалт гуймаар байна аа. Тэр дарга гээд хүн байгаа шүү дээ. Дарга нь гараад ядаж уучлалтаа гуйгаад, мэдээж холбогдох арга хэмжээ энэ тэрийг авч байгаа юм байна лээ. Тэрийгээ авах нь угаасаа угаасаа л зүй ёсны. Энэ олон нийт чинь гайхаад байна шүү дээ. Бид хэд сая ингээд Хууль зүйн байнгын хороо, комиссууд овоо ажиллаж байна. Ер нь ингээд байсан чинь л доод ийм түвшиндээ алдаа гараад байхаар энэ байгууллага эд нар чинь олон нийт юу гэж бодох билээ?

Тийм учраас мэдэгдэл энэ дүр төрхөөрөө гараад мэдэгдлээ өгөх хэрэгтэй. Би тэр комиссын гишүүний хандлагыг сэтгүүлч тайлбарлаж бичсэн байна лээ. Нарантуяа гээд гишүүнээс нь яасан чинь бичиж болохгүй шүү камераа унтраа, яах гэж над дээр орж ирж байгаа юм. Би хариулт өгч чадахгүй гээд, одоо ингээд хэвлэл мэдээллийнхнийг хүртэл тэгж өрөөндөө ороод тэр ингээд явсан гээд тэрийг хэвлэл мэдээллийнхэн биччихсэн байна лээ шүү дээ. Тэгээд манай энэ комиссынхон жоохон энэ өгч байгаа Их Хурлын мандатыг зөв ашиглаарай. Уг нь Улсын Их Хурлын 126 гишүүний өмнөөс хүний эрхийн хяналт шалгалтыг хийж бидний нүд, бидний чих болох гээд байгаа байхгүй юу. Бидний нүд, бидний чих ингээд хүний эрхийн зөрчил өөрсдөө гаргаад байхаар бид хэд хэлэх үггүй болох шинжтэй байна аа.

Тийм учраас цаашдаа энэ асуудлаа анхаар. Комиссын гишүүн комиссын дарга нь гараад олон нийтээс уучлалт гуй. Тэгээд ийм зүйл институцийн гаргаж байгаа асуудлуудыг ингээд л чимээгүй байж байгаад л ингээд л улс төрийн намын дарга эсвэл Ерөнхий сайдын хэмжээнд Ерөнхий сайд хөөрхий уучлалт гуйсан байна лээ. Хурлын дарга уучлалт гуйж байгаа байхгүй юу. Комиссын гишүүд маань өөрсдөө бүрэн бүрэлдэхүүнээ гаргаад уучлалт гуй. Би ингэж уриалмаар байна. Тэгээд шат шатандаа энэ хариуцлага янз бүрийн юмаа ойлгодог байхгүй бол чимээгүй байгаад олон нийтийн энэ янз бүрийн юм болоод ирэхээр тэгээд л ингээд л улс төрийн албан тушаалтнууд л манлайлаад л өмнөөс нь.

Д.Цогтбаатар: Би нэг юу орхигдуулчихсан байна шүү гишүүд ээ. Уучлаарай. Энэ нөгөө ажлын хэсгээ танилцуулах ёстой. Энд хэлэлцүүлж байгаа асуудалтай холбогдуулаад ирсэн байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ш.Үнэнтөгс ХЭҮК-ын Эрүү шүүлтээс Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Э.Дарханцэцэг Улсын Их Хурлын гишүүний зөвлөх гэсэн ийм 2 бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж байгаа.

Батлут гишүүний микрофоныг өгье.

Д.Батлут: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая аа.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Одонтуяа гишүүний санаачилсан энэхүү өөрчлөлтийг дэмжиж байгаа бүрэн дэмжиж байгаа. Яг үнэндээ сүүлийн үед манай батлан хамгаалах салбартай ч холбоотой асуудал нэлээн яригдлаа. Энэ хүрээнд бид бүхэн бас тодорхой чиглэлийн ажлуудыг хийж хэрэгжүүлж байгаа гэж хэлэхийг хүсэж байна. Энд Одонтуяа гишүүний сануулж байгаа энэ өөрчлөлт, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал нь ч гэсэн бидний үйл ажиллагааны чиглэлд бүрэн нийцэж байгаа учраас их баяртай байгаагаа илэрхийлье. Тэгээд одоо бид бүхэн бол Батлан хамгаалахын сайдын дэргэд Зэвсэгт хүчин дэх хүний эрхийн хяналтын зөвлөлийг байгуулаад ажилд нь оруулчихсан явж байгаа.

Мөн дээрээс нь Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу Зэвсэгт зэвсэгт хүчнийг эрсдэлээс чөлөөлье гэдэг реформыг хэрэгжүүлэх үүднээс тодорхой алхмууд хийж байгаа. 7 чиглэлийн ажлыг төлөвлөөд явж байна. Тэрний нэгэнд иргэний хяналтыг бий болгох, төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, эцэг эхийн төлөөлөл оролцсон хяналтын зөвлөлийг байгуулж ажиллуулахаар болж байгаа гээд нэлээн олон дэвшилттэй зүйлүүдийг хийж хэрэгжүүлээд явж байгаа юм. Урьд нь ч гэсэн бид бүхэн энэ чиглэлээр ажилладаг байсан уу гэвэл ажилладаг байсан. Тухайлах юм бол НҮБ-ын холбогдох дэд хороотой хамтарч хууль сахиулах байгууллагуудад Зэвсэгт хүчний хэмжээнд 1100 алба албан хаагчийг сургагч багш бэлтгэх сургалтад хамруулснаас өнөөдрийн байдлаар хүний эрхийн чиглэлээр 78 сургагч багш бэлтгэгдээд Зэвсэгт хүчний анги салбар батлан хамгаалах салбарын харьяа байгууллагуудаар байнгын хуваарийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр бидний зорьж байгаа зүйлүүд дандаа нэг зүйл рүү ингэж харж чиглэж байгаад их баяртай байна. Тэгээд энэ зүйлийг энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаагаа илэрхийлье ээ. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Би нэг товч хэдэн зүйл хэлчихье гэж бодож байна. Энэ Одонтуяа гишүүнд бас талархал илэрхийлмээр байна. Энэ ингээд нэлээн олон жил яригдаад л гэхдээ энэ дээр ингээд тодорхой арга хэмжээ авч байж л энэ үзэгдэл юм зогсоно. Тэгээд энийг аягүй олон хүмүүс юу гэж хараад байдаг вэ гэхлээр нэг БХЯ-ны дангаараа өөрсдөө л хийх асуудал юм шиг бодоод байх юм бол бид нар тэгээд өөрсдөө нэг их цэвэрхэн улсууд ингээд хөндий байгаад Батлан хамгаалах яам гэдэг чинь Монгол Улсын бүрэлдэхүүн нэг салшгүй л хэсэг аавын хүүхдүүд л тэнд байж байгаа. Тэгээд энийг чинь яг хамтарч бүгдээрээ тал талаасаа санаачилга гаргаж оролцож байж л шийдэх ёстой асуудлуудын нэг. Тэр үүднээсээ Одонтуяа гишүүн яг ингээд санаачилга гаргаад асуудлыг зүгээр яриад орхих биш хууль болгоод хуулийн төсөл санаачлаад оруулаад ирж байгаа нь их чухал байгаа юм аа. Тэгээд энэ дээр харин Батлан хамгаалах яам нээлттэй бас ингээд өөрөө хандаад нөгөө байгууллагаа хамгаалаад үгүй манайх ёстой нэг төгс байгууллага гээд ингээд ярихгүй энэ дээр бид нар анхаарч байна. Энэ хуулийг дэмжиж байна гээд ярьж байгаа нь их зөв. Хандлага үүгээрээ зогсохгүй, та хэрэгжүүлж ажиллах дээр энэ дээр их анхаарч ажиллах ёстой. Яагаад гэвэл бид маань хууль гаргаад л байдаг хэрэгжилт дээрээ очоод л гацаж унаад байдгийг тал талдаа бодолцож үзээрэй гэж би хэлмээр байна аа.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Санал хураалтдаа бэлтгэе.

Санал хураалтдаа бэлдсэн байна гишүүд. Монгол Улсын ХЭҮК-ын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж

чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

61.6 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн оруулах вэ? Уянгахишиг гишүүн унших уу? Тэгье. Уянгахишиг гишүүн.

14.40 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хоёрдугаар асуудал. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна аа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын нэр бүхий 37 гишүүн хамтран Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачиллаа. Сүүлийн жилүүдэд орон сууцын захиалгын гэрээтэй холбоотой маргаан залилангийн жишээтэй үл нэмэгдэж иргэдийн хөрөнгө, цаг хугацаа, хууль ёсны ашиг сонирхол ихээхэн хохирол учруулах болсон. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалах зохих нууцад хамаарахаас бусад мэдээллийг иргэн, хуулийн этгээд заасан үндэслэл журмын дагуу хүлээн авах авах нь хууль бус үйлдэл санхүүгийн гэмт хэргийн хохирогч болж хохирохоос урьдчилан сэргийлэх чухал алхам гэж үзэж байна. 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг нээлттэй, хаалттай, хязгаартай буюу энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан этгээдэд өгнө өө гэж хуульчилж, нэрийн сан, хаягийн сан, хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчдийн нэр эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, нэр, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн өөрчлөгдсөн, байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээлэл нээлттэй байхаар заасан бөгөөд

Улсын бүртгэлийн байгууллагад байгаа зарим мэдээлэлтэй иргэд чөлөөтэй танилцах боломж нэгэнт тогтсон практик болон хэвшиж байна. 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн нээлттэй, хязгаартай, хаалттай гэж мэдээллийг ангилсан бөгөөд нийтийн мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах төрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байх, хүн хуулийн этгээдийн хуулиар хязгаарлалт тогтоогдоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар иргэдийн орон сууцын залилах гэмт хэргийн хохирогч болохтой холбоотой харилцаанаас үүсэх санхүү хөрөнгө, цаг хугацаа, гэрээний харилцаанууд өсөх эрсдэлийг бууруулах сэргийлэх боломжтой гэж үзэж байна аа.

Орон сууц захиалгын гэрээгээр иргэн, хуулийн этгээд гэрээ байгуулан хөрөнгө оруулсан боловч зөвхөн барилгын компани барьж байгаа гүйцэтгэгч болон болон захиалагчийн аль нэг нь хуулийн этгээдийн дангаар өмчлөх эрхийг бүртгэгдэж байгаагаас үүдэн захиалгаар гэрээ байгуулсан иргэд хуулийн этгээдийн эрх хөндөгдөж зөрчигддөг. Барьж дуусаагүй барилгыг улсын бүртгэлд бүртгүүлж өмчлөх эрхийн гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээд нь тухайн барилгыг удаан хугацаатай өндөр хэмжээний зээлийн барьцаанд тавьж бүртгүүлдэг. Үүний улмаас тухайн захиалгын гэрээ байгуулж хөрөнгө оруулсан иргэн хуулийн этгээд нь өөрийн өмчлөлд бүртгүүлэх процесс, тухайн барилгыг улсын комисст ашиглалтад орсны дараа удааширдаг, эрсдэлд ордог практикууд нэлээд байна аа.

Мөн тухайн зээл барилгыг барьцаалж зээл авсан барилгын компани нь төлбөрөө төлөөгүйн улмаас мөн бусад асуудлаар хууль хяналтын байгууллага шалгаж нийтийн зориулалтаар дуусаагүй барилгыг захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх тохиолдол багагүй гардаг аа.

Иймд:

Иргэний хуулийн 145.2-т заасны дагуу эрхийн бүртгэлд бүртгүүлсэн хэлцэл болон барьж дуусаагүй барилга дээр үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг бүртгүүлэх тухай шаардлагыг хангах агуулга бүхий нийтийн зориулалттай орон сууцын захиалгын гэрээний хэсгээр барьцаанд авахыг хязгаарлаж давхардуулан хөрөнгө босгохоос сэргийлэх буюу зээл олгож буй банк санхүүгийн байгууллага болон орон сууцын захиалгын гэрээ байгуулж хөрөнгө оруулсан иргэдийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой. Одоо үйлчилж буй хууль эрх зүйн хүрээнд бол бүх дуусаагүй барилга улсын бүртгэлд бүртгэгддэггүй, сайн дурын үндсэн дээр явж ирсэн учраас иргэдийн захиалгын гэрээг улсын бүртгэлд бүртгэхэд тухайн тухайн барилга нь дуусаагүй барилгаар бүртгэгдсэн тохиолдол боломжтой, бүртгэгдээгүй мэдээллийг авах боломжгүй байна аа.

Иймээс нэг ижил тоот дээр иргэдээс давхардуулан захиалга авч иргэд хөрөнгө оруулагчдыг хууран мэхлэх тохиолдол олон байгааг хууль хяналтын байгууллага олон нийт хэлж ярьсаар байна аа. Тодруулбал сүүлийн жилийн орон сууц захиалгыг авч бусдыг залилах гэмт хэргийн төлөв байдлыг судалж, дүн шинжилгээ хийхэд 3613 иргэнд 204.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд 300 гаруй хохирогчийн 15 орчим тэрбум төгрөгийн хохирол барагдуулах ажиллагаа явагдаж байна аа. Мөн барьж дуусаагүй нийтийн зориулалттай орон сууцын барилгын ажлыг эхлэхэд тухайн барилга, байгууламж, албан ёсны хаяг эсвэл урьдчилсан хаягийг олгодоггүй учраас уг

зохицуулалтыг бий болгох замаар олгох нь зүйтэй байна аа. Бүртгэлийн одоо явж буй практикт барилгын компани төслийг өөрийн өгсөн нэрээр нэрлэж А, Б блок гэх зэргээр нэрлэж иргэдээс захиалга авдаг бөгөөд улсын комисс ажиллаж тухайн барилга ашиглалтад орохоор хаяг зөрөх үүнээсээ болоод иргэдийн гэрээний хэрэгжилтийг хангах, хууль шүүхийн байгууллагад хандах зэрэг асуудал дээр мэдээллийн зөрүүтэй байдлаас цаг хугацаа алдах хөрөнгө мөнгөөрөө хохирох зүйлүүд нэлээд тохирч байна аа.

Иймд ашиглалтад оруулах гэрчилгээ олгоогүй боловч барьж дуусаагүй барилгыг эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгүүлж өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүсгэсэн эсэх, зөвшөөрөл заагдсан нийтийн зориулалттай орон сууцын зориулалтаар барьж байгаа барилга байгууламж дээр үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг бүртгүүлэх тухай шаардлагыг хангах агуулга бүхий хэлцэл урьдчилсан тэмдэглэгээ байгаа эсэх. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон Нийтийн мэдээллийн хууль, Барилгын тухай хуулиудаар уялдааг хангаж, уг асуудлыг тусгаж нээлттэй байдлаар оруулахаар тусгалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг болон Улсын Их Хурлын холбогдох тогтоолын төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Хуулийн төсөл батлагдсанаар орон сууц захиалгын гэрээгээр халхавчилж, залилах гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, давхардуулан гэрээ байгуулахаас иргэдийг хамгаалж, мэдэх эрхээр хангагдах боломжийг бүрдүүлж нийгэмд энэ асуудалдаа үүсэж байгаа зарим асуудлыг шийдвэрлэж чадна гэж үзэж байгаа тул Үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан танхимд орж ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. О.Оюунзул ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Д.Сайнжаргал ЦЕГ-ын Мөрдөн шалгах албаны Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, Э.Отгонтунгалаг УБЕГ-ын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, Ө.Өнөрлхам УБЕГ-ын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хуралдаанд оролцож байна аа.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Пүрэвдаваа гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүнийг оруулаарай. Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Баярлалаа. Энэ орон сууц залилан эсвэл энэнтэй холбоотой асуудлаас болоод иргэд хохирч байгаа асуудал нийгмийн үзэгдэл болтлоо өргөжсөн. Тэгэхээр энэ асуудлыг шийдэх гээд бид Өргөдлийн байнгын хороон дээр түрүүн 12 сараас хойш ингээд ажиллаж байгаа. Энэ асуудлыг гарч ирэхэд салбарын сайдууд өө энийг ёстой таслан зогсооно, хууль санаачилна гэж хэлж байсан боловч 6 сарын 10 гэхэд аль ч яамдуудаас хууль орж ирээгүй. Тэгэхээр энийг бас тодорхой хэсгийг нь шийдчихье гээд ийм хууль оруулж ирж байгаа хувь гишүүн Сайнзориг гишүүн санаачлаад орж ирж байгаад талархаж байгаа. Яагаад гэвэл бид нар энэ хууль эрх зүйн орчин дутмаг хяналтын систем байхгүй, задгай явснаас болоод олон 10 мянган өрхүүд орон сууцдаа орж чадалгүй хохироод үлдчихсэн олон жил ингээд цөхрөөд явж байгаа асуудлууд байгаад байгаа юм аа.

Тэгээд энэ асуудлыг яах вэ ингээд харахаар хууль, эрх зүйн шийдэл бол ингээд бүртгэлжүүлж шийдье гэдэг ийм шийдэл орж ирж байгаа юм байна. Тэгэхдээ эхний ээлжид би нэг хэдэн асуулт асуумаар байгаа юм.

Нэгдүгээрт Улсын бүртгэлийн тухай хуульд бол тэмдэглэгээ хийгээд нэг сантай болгоно оо гэж байгаа юм. Тэгээд энэ сан дээр ер нь энэ ямархуу мэдээллүүд орох вэ? Бид нарын 2, 3 удаагийн хэлэлцүүлэг дээр бол ерөөсөө энэ барилгын орон сууц барьж байгаа компаниудын тэр газрын зөвшөөрөлтэй юм уу, барилгын зөвшөөрөлтэй юм уу хууль ёсны дагуу хий хийгдэж байгаа юм уу гэдэг мэдээллүүд нь бүгдээрээ ил тод байх юм бол захиалж байгаа иргэд нь ч хүртэл тэндээс ороод би энд юу гэдэг юм энэ нэг сайхан ап гэдэг газар орон сууцад захиалга өгөх гэж байна. Энэ үнэхээр хууль ёсны юм уу, үгүй юм уу эсвэл залилангийн шинж чанартай юм уу гэхээр харахад их дөхөм болно оо гэдэг асуудлыг хэлж байсан.

Тэгэхээр энэ цахим сан мэдээллийн сангийн тухай ямар ямар мэдээлэл орох байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асууя.

Хоёрдугаарт энэ Иргэний хуульд өөрчлөлт оруулж орж ирсэн байна. Ер нь бол тодорхой хэмжээний энэ бүртгэл урьдчилсан бүртгэл хийгдэхээс нааш барилгын захиалга авч болохгүй гээд. Тэгээд энэ ийм ер нь олон улсад жишиг байна уу эсвэл Дээд шүүхээс энэ Иргэний хууль дээр санал авсан болов уу гэдэг нэг тодруулах асуулт байна.

Гуравдугаарт, дагаж орж ирсэн үл хөдлөх хөрөнгийн татвартай холбоотой нэг хууль байгаа. Тэгээд татвартай холбоотой мэдээж яах вэ, энэ бүртгүүлэх бүртгэлтэй, холбоотой асуудлыг нь ойлгож байгаа. Гэтэл яг энэнтэй үзэл баримтлалтай холбоогүй, гэр хорооллыг газрыг дахин төлөвлүүлэх барилгажуулах хүрээнд баригдсан барилга байгууламж болон эрчим хүчний эх үүсвэр бүхий барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас ашиглалтад оруулах гэрчилгээ олгосноос хойш эхний 5 жилд 100 хувиар хөнгөлнө гэсэн ийм заалт ороод ирж байгаа байхгүй юу. Тэгээд би бол энэ хуулийн яг үзэл баримтлалтай энэ хамаагүй юм болов уу гэж харж байгаа юм. Тэгээд яагаад ийм юм оруулж ирсэн юм бэ гэдэг энэ 3 асуултад эхлээд эхлээд хариулт авъя.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Нэгдүгээрт ер нь зүгээр нөгөө тодорхой хэмжээний яг процесс нь яаж явах гэж байна гэхээр барилгын ажил эхлэх зөвшөөрөл олгоход урьдчилсан

хаяг олгох гэж байгаа. Одоо хаяг олгогддоггүй. Заавал улсын комисс ажилласны дараа хаяг олгогддог учраас барилгын компаниуд өөрийн үүсгэсэн хаяг буюу А, Б блок гээд явчхаж байгаа. Яг урьдчилсан хаяг олгогдох энэ гол зохицуулалт нь тухайн барилга үндсэндээ газрын эрхийн зөрчилгүй, халуун дулаанаар хангагдах техникийн боломжтой. Хот төлөвлөлтийн төлөвлөгөөнд орсон гэж үзэж байгаа учраас одоо хаяг олгогдох буюу хаалганы хаяг хүртэл олгогдох юм. Өөрөөр хэлэх юм бол нэг орцтой 20 айлын орон сууц байвал 20 хаяг олгогдоод ирнэ. Яг энэ 20 хаяг дээр тодорхой тэр хаягийн буюу барилга дээр бүхэлдээ эсвэл тодорхой тэр яг үл хөдлөх хөрөнгийн бие даасан үл хөдлөх хөрөнгө болох хэмжээгээрээ ер нь аливаа банкны барьцаанд байна уу эсвэл хэн нэг этгээд урьдчилж захиалга өгөгдсөн байна уу гэдэг эрхийн төлөв л энэ дээр гарч ирнэ. Эрхийн төлөв буюу тэр хаалган дээр 9 тоотыг захиаллаа гэхэд тэрийг Сайнзориг захиалсангүй юу гэдэг нь мэдэгдэхгүй. Зүгээр захиалгатай банкны барьцаанд байгаа гэж. Энэ мэдээллийг авсны үндсэн дээр захиалгын гэрээ өгөх үү, үгүй юу энэ орон сууцыг худалдаж авах уу үгүй юу гэдэг энэ асуудлаа иргэд маань гэрээ байгуулахдаа нягталж болох юм аа. Бүртгэлийн мэдээлэл дээр бол тодорхой бүртгэлийн суурь мэдээллүүдийг мэдээллийн хүрээндээ яригдах зарим мэдээллүүдийг ил олгож байгаа.

Дээрээс нь Барилгын тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиараа яг Номинчимэг гишүүний хэлж байгаа шиг газрын эрхийнх нь мэдээлэл нээлттэй болно. Тухайн барилга дээр халуун дулааны хангагддаг техникийн нөхцөл олгосон уу, үгүй юу энэ нь ямар шийдвэрүүд дээр гарсан юм, энэ өөрчлөлт орсон уу гэдэг мэдээллүүд нь ил тод болно.

Дээрх эрхийн төлөв мэдээллүүд ил болох энэ бололцоотой байдлаар орох юм аа. Тэгээд энэ холбогдох дэд бүтцийг барилгын болон хууль зүйн дотоод хэргийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллага энэ иргэдийн мэдээллээ шалгаж болох мэдээллийн санг бүрдүүлэх асуудал байгаа. Суурь нь угаасаа Улсын бүртгэлийн ерөнхий хуулиар тавигдчихсан. Энийгээ зүгээр сайжруулах тодорхой алхмууд хийгдэх ёстой гэж харж байгаа.

Хоёрдугаарт орон сууцын энэ барилга дээр л бид хэд анхаарал тавиад зөвхөн дуусаагүй нийтийн зориулалттай орон сууц гэж байгаа шүү. Бүх барилгыг заавал улсын бүртгэл дуусаагүй байхад нь бүртгүүлэх гэж би шаардлага тавиагүй. Зөвхөн орон сууцын зориулалт дээр тавьж байгаа энэ барилгуудыг бүртгүүлж байж дараа нь иргэдээс захиалга ав гэж байгаа юм. Бүртгүүлээгүй байж байж иргэдээс ингээд макет үзүүлж байгаад гэрээ хийж болохгүй шүү. Ямар нэгэн байдлаар улсын бүртгэл дуусаагүй барилгаар бүртгүүлж тусдаа гэрчилгээ ав гэж байгаа. Гэрчилгээг 2 янз болгоё гэж байгаа. Одоо үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээнүүд дууссан дуусаагүйгээсээ үл хамаараад Ү гэрчилгээ олгож байгаа, дуусаагүй барилга дээр Д гэрчилгээ олгоё гэж байгаа. Ингэх юм бол гэрчилгээнээс нь хараад хүртэл иргэд мэднэ. Дуусаагүй барилга байгаа юм байна гээд. Тэгээд ийм зүйл байгаа. Энэ дээр квот тавьж болох уу үгүй юу гэдэг хэлэлцүүлгийн явж байгаа саналууд ирсэн. Заавал барилгын 30 хувь нь баригдчихсан байж байж захиалга ав ч гэдэг юм уу.

Тэгэхээр энэ нөгөө 30 хувьдаа хүрсэн үү, 40 хувьдаа хүрсэн үү гээд ингээд явахаар л нэг төрийн байгууллагуудын хувийн бизнес дээр шантааж үүсгэх ийм зүйл болох учраас одоо энэ асуудлуудаа тодорхой хэмжээнд ерөнхийдөө явж байгаа практик нь тогтчихсон. Засгийн газрын тогтоолын түвшиндээ дуусаагүй барилгыг бүртгэх ийм журмынхаа хүрээнд шийдээд явж байгаа энэ практикаараа явах нь зүйтэй гэж үзсэн ийм зүйл байгаа.

Тэр Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай тухай хууль дээр орж ирсэн 1 дүгээрт яах вэ энэ дуусаагүй барилгыг бүртгэж гэрчилгээ олгож байгаа бол Улсын комисст орох хүртэл хугацаанд үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөх нь зүй ёсны хэрэг. Яг энэ дээр татвар тавигдаад маргаж явсаар байгаад сая хууль өргөн баригдах хугацаатай давхцаад Улсын дээд шүүхийн шийдвэр гараад татвар тавьж болохгүй юм байна гэдэг шийдвэр гарсан. Тэгэхдээ энэ хуулиар ингээд баталгаажуулаад өгөх нь зөв байгаа.

Хоёрдугаарт энэ орон сууцтай холбоотойгоор иргэдийн хохироод байгаа юм нь дахин төлөвлөлт.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариул наадах чинь чухал юмнууд явж байна.

П.Сайнзориг: Номинчимэг гишүүн үзэл баримтлалтай хамаатай юу гэж асууж байгаа. Дахин төлөвлөлтөд ороод байшинг нь нураачхаад нөгөө барилгаа барихгүй байгаад байдаг. Тэр барилгын нөгөө бүртгэл улсын бүртгэл дээр байгаад байдаг байхгүй юу нөгөө барилга нь. Тийм учраас тэр дахин төлөвлөлтөд ороод нураагаад шинээр барих хугацаанд нь татварт ноогдуулж болохгүй шүү гэдэг тэр зүйлийг нь хэлж байгаа. Ийм байдлаар үндсэндээ иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж байна. Нэгэнт дахин төлөвлөлтөд ороод нурааж байгаа учраас тэр хугацаанд нураагаад шийдвэр гараад дахиад тэрийг улсын комисс хүлээж авах хугацаанд бол татвар төлөхгүй ээ. Яах вэ энэ эрчим хүчний эх үүсвэрүүдийг дэмжих үүднээс иргэдийг орон сууцтай орон сууцын энэ нийлүүлэлтийг нэмэгдүүлэх гол үүсвэр дэд бүтцийн асуудал байгаа. Энэ дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж хийхдээ бас энэ эрчим хүчний эх үүсвэрүүдийг барьж байх хугацаанд бол бариад тодорхой хугацаанд нь татвараас чөлөөлж болох юм гэдэг л энэ бодлогын дэмжлэгээр уялдуулж бодсон ийм зүйл байгаа юм аа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

О.Номинчимэг: Үл хөдлөхийн татвар дээр яах вэ тэр ашиглалтад орсноос хойш байна шүү дээ энэ гэрчилгээ олгосноос 5 жил 100 хувиар хөнгөлнө гэхээр таны ярьж байгаа хариулттай логикийн хувьд хөгжилтэй л байна л даа. Энэ чинь ашиглалтад орсных нь дараа үл хөдлөх татварыг нь 5 жил хөнгөлөх гээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ барилгын компанидаа л ашигтай ийм заалт байгаад байна.

Хоёрдугаарт энэ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 31.2-т байгаа нөгөө заавал хийх бүртгэлд урьдчилсан тэмдэглэгээг оруулж байгаа. Энэ хэн энийг субъект нь хэн очиж хийлгэх юм бэ гэдэг дээр нэг тодруулаад хариу өгөөдхөөч.

Дээр нь Иргэний хуультай асуудал байна. Би Иргэний хууль дээр орж байгаа өөрчлөлтийг харахаар 1 дүгээрт энэ гэрээ захиалгын гэрээ байгуулахыг хориглох заалт бол гэрээний эрх зүйтэй холбоотой асуудал байхгүй юу. Хэзээ яаж хийж болох вэ? Тэгэхээр энэ нөгөө улсын бүртгүүлэх эрхтэй холбоотой заалт биш байгаад байгаа. Тэгэхээр байршлын хувьд буруу байна гэж харж байна.

Хоёрдугаарт тэнцүү эрхтэй байх түрүүлж бүртгүүлсэн эрх давуу байх байгаа. Нэг өдөр бүртгүүлсэн байх юм бол тэнцүү гэж үзнэ гээд. Тэгээд нэг өдөр бүртгүүлэх юм бол тэнцүү.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүн гүйцээгээд асуух уу? Нэг минут өгье.

О.Номинчимэг: Үгүй үгүй би дараа нь.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн хариулах уу?

П.Сайнзориг: Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хууль дээр байгаа байхгүй юу. Ямар ямар барилгуудыг чөлөөлдөг вэ гэхээр иргэдийн эхний 2 орон сууц болон чөлөөлдөг. Яг энүүнтэй адилхан гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгын хүрээнд баригдсан барилга байгууламж болон эрчим хүчний эх үүсвэр гэж байгаа шүү. Шинээр станц барьж байгаа. Энийг бодлогын хүрээнд дэмжээд энэ орон сууцын бодлогыг л нийлүүлэлтийг дэмжье гэж байгаа байхгүй юу. Барилгын хүрээнд би зүгээр үл хөдлөх хөрөнгийн албан татвараас ашиглалтад оруулах гэрчилгээ олгосноос хойш 5 жил чөлөөлөөд өгье өө л гэж байгаа юм. Энэ иргэд чинь бас тодорхой хэмжээнд энэ өртгийг бууруулж өгөөд явбал дахин төлөвлөлтийг дэмжиж оролцох нь бас одоо зөв юм л гэж үзэж байгаа юм.

Тэгэхгүй иргэдэд үнэндээ хэлэхэд хаширчихсан газраа өгөөд алдаж байна. Дахин төлөвлөөд нөгөө барилгын команд барьж өгдөггүй улсын комисст орсноосоо хойш гэрчилгээ нь гардаггүй ийм тохиолдлууд ч ингээд байж байгаа юм. Тэгэхээр энийг л бодлогын хүрээнд энэ утаа униараасаа салах орон сууцжуулах бодлогыг дэмжиж өгөх хүрээндээ л.

Д.Цогтбаатар: Соронзонболд гишүүний микрофон. Номинчимэг гишүүн тодруулах уу? Нэг минут өгье.

О.Номинчимэг: Хэн нөгөө нэг тэр урьдчилсан тэмдэглэгээг заавал хийнэ гэхчхэн байгаа. Хэнд энэ үүрэг нь очих юм бэ? Хэн очиж яг улсын бүртгэл дээр урьдчилсан тэмдэглэгээг хийх үүргээ хүлээх вэ гэдгийг Ү үл хөдлөх дэлгэрэнгүй бүртгэлийн тухай хууль дээр заавал гэж оруулсан байгаа учраас асууя. Иргэний хууль дээр бол тэр тэнцүү эрх гэж үзэх нь хасагдсан юм байна. Энэ тракц дээр нь юм байна. Өмнө нь юм байна. Гэхдээ яах вэ 182.5-д биш гэрээний эрх зүй дээр орох ёстой байсан заалт байна даа л гэдгийг нь харж байна. Тэгэхээр үүрэг нөгөө хэн дээр байхаас авхуулаад иргэд маань үнэхээр яг очиж бүртгүүлэх үү, нөгөө нотариатын баримт бичиг нь яах вэ гээд олон процессын асуудал байдаг юм байна лээ л дээ. Одоо энд ажлын хэсэгт бол яг энэ манай энэ Өргөдлийн байнгын хороон дээр 2, 3 удаа хэлэлцүүлэг хийхэд байсан хүмүүс маань байна. Маш нарийн мэдээлэлдээ юун дээр очоод иргэдэд үнэхээр хүндрэл гараад байна гэдгийг мэдэж байгаа хүмүүс байгаа байх.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Номио гишүүн зөв өнцгөөс асуучихлаа.

Нэгдүгээрт энэ гэрээ байгуулж байгаа учраас гэрээний талууд энэ нэхэмжлэлийн гэдэг юм уу тодорхой энэ гэрээг хангах энэ шаардлагыг бүртгүүлэх асуудал аль аль талд нь байгаа. Тэгэхдээ энэ хуулийн Барилгын хуулиараа

барилгыг барьж байгаа компани буюу энэ захиалга авч байгаа компанид үүрэгжүүлээд оруулчихсан байгаа. Иргэдээс захиалга авч ийм гэрээ контракт байгуулж байгаа бол энийгээ улсын бүртгэлд бүртгүүлэх буюу мэдээллээ нийлүүлэх үүргийг нь барилгын хуулиараа үүрэгжүүлж өгч байгаа. Нотариатаараа дамжуулаад бас энэ хийх боломжтой. Өөрөөр хэлэх юм бол Нотариатын тухай хуульд өмнө нь орсон өөрчлөлт дээр бол нотариат нөгөө улсын бүртгэлийн байгууллагад мэдээлэл нийлүүлэгчээр орсон. Үнэхээр иргэд маань тодорхой хэмжээний үл хөдлөх хөрөнгийн холбоотой эрхүүд үүсгэж байгаа бол нотариатаар орох хууль эрх зүйн зохицуулалт байгаа.

Түүгээрээ нотариатаар оруулаад энэ мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад илгээх энэ бололцоо нь байгаа. Зүгээр дагаж мөрдөх журмын нөгөө тогтоол байгаа. Энүүгээрээ л нөгөө.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хариулах уу? Оюунзул дарга үгүй юу? Хариулт хангалттай гэж үзэж байна. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Би энэ хуулийг санаачилж байгаа гучаад гишүүдийн нэг байгаа юм аа. Тэгээд яах вэ ер нь нийт олон нийтэд ойлгомжтой болох үүднээс нь Сайнзориг гишүүн бас энэ ялангуяа энэ байр дөнгөж одоо дуусаагүй барилгын гэрчилгээ аваад захиалга авч байгаа үед иргэд юун дээр анхаарах ёстой вэ гэдэг дээр нэлээн дэс дарааллын хувьд сайн дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч гэж бодож байгаа юм. Яагаад гэхээр сая Номинчимэг гишүүн энэ Өргөдлийн байнгын хороон дээр бол яг энэ орон сууцын захиалгаас хохирсон иргэдийн асуудал дээр нэлээн ажлууд хийгээд уулзалтууд хийгээд энэ асуудлуудыг яаж шийдэх вэ гээд маш олон хэлэлцүүлэг зохион байгуулсан шүү дээ. Тэгээд тэрэн дээр харж байхад бүр ингээд ямар ч барилгын зөвшөөрөл байхгүй барилга дээр хүртэл захиалга авсан тохиолдол гарсан.

Нөгөө нэг хэсэг гомдол нь юу байна гэхээр нөгөө барилгын компани нь нөгөө дуусаагүй барилгын гэрчилгээгээ банк санхүүгийн байгууллагууд барьцаалчихдаг. Нөгөө хүний захиалсан байр нь барьцаанаас гардаггүй. Тэрнээс болоод нөгөө хүн гэрчилгээгээ авч чадахгүй ингээд олон жилээр хохирдог ийм асуудлууд гараад байгаа байхгүй юу. Тэгэхээр зүгээр яах вэ одоо энэ хуулийн төсөл дээр ялангуяа нотариаттай холбоотой хуулийн асуудал ерөөсөө хөндөгдөөгүй байгаа.

Тэгэхээр яагаад хөндөгдөөгүй вэ гэхээр ихэнх барилгын компаниуд захиалгаа авахдаа заавал нотариат дээр очиж давхар давхар баталгаажуулаад ингээд явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ процессыг нэг яг иргэдэд ойлгомжтой байдал талаас нэг сайхан тайлбарлаад өгөөч гэж хүсэх гэсэн юм.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би бас зарим мэдээллүүдийг ХЗДХЯ-ны албан ёсны сайтуудаас харж байгаа мэдээллийг үзсэн. Ер нь одоо нотариатууд бол бас мэдээлэл нийлүүлэгч болчихсон юм. Тэгээд энэ мэдээлэл нийлүүлэгчийн хүрээнд үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой энэ транзакшнуудыг давхар давхар гэрээ байгуулахгүй анхны тэр яг зохигч буюу талуудын хооронд байгуулж байгаа энэ гэрээнүүдийг илгээх байдлаар явчхаж байгаа юм. Хуучин бол нөгөө гэрээний үнийн дүнг 2 янзаар ч юм уу, 3 янзаар яагаад нэгийг нь татварт өгдөг, нэгийг нь бүртгэлд өгдөг ийм гэрээнүүд байсан учраас нотариатуудыг мэдээлэл нийлүүлэгчээр ороод

ирэхээр давхар тэр гэрээ байгуулах боломжгүй болоод яг л бодитой гэрээгээ улсын бүртгэлд өгөхөөс өөр аргагүй болчихсон. Энэ нь бол одоо ингээд иргэдийнхээ тал талын эрх ашгийг хамгаалж байгаа ийм зүйл болсон юм аа. Тийм учраас Нотариатын хууль хөндөгдөөгүй. Тэгэхдээ ХЗДХЯ-ан дээр явж байгаа юугаар нотариатууд бүүр ингээд онлайнаар цаашдаа ажиллах тэр бололцоо бүрдүүлэхээр хуулийн төсөл явж байгаа юм байна лээ. Тун удахгүй энэ орж ирээд иж бүрнээр орж ирж ирж байгаа учраас энэ дээр одоо тодорхой хэсгийг нь барьж аваад ч юм уу хөндөх шаардлагагүй юм байна гэж үзсэн. Тэгээд нотариатын үйлчилгээ нэлээн цахимжиж цахим гарын үсгийнхээ хэрэглээг улам нэмэгдүүлж заавал тойрог гэхгүйгээр аль ч нотариатаар өөрсдийнх нь сонгож авсан нотариатаар энэ үйлчилгээгээ барилгын гэдэг юм уу иргэн ч гэсэн хийгээд явах энэ бололцоо бүрдэх юм байна гэж ХЗДХЯ-нд явж байгаа хуулийн хэлэлцүүлэг болоод үзэл баримтлалын төслийг хараад явсан. Энэ удахгүй орж ирэх юм байна гэж ойлгосон.

Хоёрдугаарт, Соронзонболд гишүүн маань яг л зөв асуулт л даа. Би барилгын компаниудын үйл ажиллагааг тэр чигт нь юу гэдэг юм хязгаарлахыг хүсээгүй. Аль болохоор нийтийн зориулалттай орон сууц барьж байгаа бол заавал бүртгэлд бүртгүүлж байж дуусаагүй барилгын гэрчилгээ авч байж иргэдээс захиалга аваарай. Макет үзүүлж ч юм уу, элдэв газрын эрхийн зөрчилтэй халуун дулаанаар хангагдах техникийн нөхцөл нь гараагүй байж байхад иргэдээс ерөөсөө захиалга авч болохгүй гэдэг байдлаар хандаж энэ хязгаарлалтыг хийж өгч байгаа. Ингээд явж байгаа нь энэ салбар дээр яг хууль ёсны дагуу явж байгаа барилгын компаниудыгаа хамгаалах нэр хүндийг нь хамгаалах нэг зорилго байгаа.

Хоёрдугаарт урьдчилсан хаяг олгогдоод ингээд явах юм бол иргэд ч гэсэн санаа амар байж болно. Техникийн болон халуун дулаан нь хангагдах юм байна гэж нэг ёсондоо баталгаа өгч байгаа учраас урьдчилсан хаяг олгож байгаа гэж өгсөн үг. Энэ хүрээндээ магадгүй зүгээр түрүүний жишээгээ л ярья. Нэг орцтой 20 айлын орон сууц байлаа гэхэд 5 дээр нь захиалга авчихвал тэр 5-ыг ерөөсөө банкны барьцаанд тавьж болохгүй л гэс гэсэн үг. Ингээд иргэд хохироод байж болохгүй. 15-аа бол мэдээж барилгын компани захиалга барьцаанд тавиад мөнгөө босгож болно.

Тэр 15 дээр нь хожим нь иргэдээс захиалга авах юм бол иргэд маань нягтлаад үзэх байхгүй юу. Банкны барьцаанд ийм хэмжээнд байгаа юм байна. Миний нэхэмжлэлийн шаардлага банкны дараагаар орж ирж байгаа юм байна. Тэгээд энийгээ гэрээ контракт дээрээ илүү их тодруулж тусгах тэр мэдээллийг нь л иргэддээ өгөх гээд байна гэсэн үг. Эрсдэлээ тооцох гээд байна гэсэн үг. Тэгэхээр ийм бололцоог нь олгож олгож байгаа юм аа. Тэгээд иргэд анх анхнаасаа гэрээ явуулаад төлбөрийн дэс дараалал буюу тодорхой мөнгөнүүдээ өгнө гэххэд байхад тэр 5 орон сууцын жишээ нь дахин дахин банк ч байдаг юм уу, аливаа санхүүгийн зээл авах үүднээс гэдэг юм уу барьцаанд тавьж болохгүй ээ. Иргэдийн энэ орон сууц авах гэж байгаа мөнгө бол тийм бага үнийн дүнтэй биш. Насаараа цуглуулсан зээл, хүү авсан өмнөх хашаа байшин байдаг юм уу орон сууцаа зарж байгаад өгчихсөн эсвэл ах дүү амраг садан хэн нэгэн нь гадаадад хүч хөдөлмөрөө зарцуулж олж ирж байгаа мөнгийг л урьдчилгаа болгож өгч байгаа. Улсаас энэ хэсгээр нь хязгаарлая гэж байгаа юм. Энэ барилгын салбарын үйл ажиллагаанд тэр болгон нөлөөлөхгүй байх. Энийгээ бас манай барилгын компаниуд бас тооцож байж л иргэдээсээ захиалга авах энэ юмаа төлөвлөх тэр бололцоог нь олгож байна л гэж харах хэрэгтэй байгаа юм аа. Баярлалаа танд.

Д.Цогтбаатар: Соронзонболд гишүүн тодруулаад асууя.

Л.Соронзонболд: Тэр иргэд нотариат дээр очоод нөгөө захиалгын гэрээгээ бүртгүүлж байгаа. Тэр үед хамгийн гол үүсэж байгаа давуу тал нь болохоор нөгөө нотариат маань үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн систем рүү хандаад нөгөө барилгын гүйцэтгэж байгаа компанийн тэр тухайн захиалах гэж байгаа хаяг, тоот, хаяг дээр өөр ямар нэгэн тэмдэглэгээ байна уу үгүй юу гэдгийг шалгаж байгаа.

Тийм энэ шалгах эрхийг нь бол нотариатад нээлттэйгээр өгч байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ маань яг аль хуулийн төсөл дээр ингэж тусгаж байгаа вэ гэдгийг асуух гэсэн тодруулах гэсэн юм.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг хэддүгээр микрофон? 4 дүгээр микрофон. Нэрээ хэлээд танилцуулаад яваарай 4 дүгээр микрофон.

Э.Отгонтунгалаг: Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Отгонтунгалаг хариулъя аа. Нотариатын процесс нь болохоор яг мэдээлэл зуучлах хүрээнд явагдаж байгаа. Улсын бүртгэлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу нотариатч мэдээлэл нийлүүлнэ гэсний дагуу нотариат дээр хийгдэж байгаа гэрээ хэлцлийг улсын бүртгэлийн мэдээллийн санд нийлүүлээд тэрнийг нь үндэслээд манайх бүртгэлийг нь хөтлөөд явж байгаа.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Ер нь тун чухал хууль байна даа. Тэгээд одоо яг ямар нэмэлтүүд нь орсон юм гэдэг дээр нэлээн ажиллая гэж бодож байна. Өмнө нэг Монгол Улсад нэг ХЗХ-дын хохирогчдын асуудал гэж нэг том давлагаа яваад улс орон даяар маш олон хохирогчтой нэг хэрэг гарсан даа. Яг тэрүүн шиг ийм асуудал Монголд гаргах гээд байгаа шүү. Энэ орон сууцын захиалга өгөөд хохирсон иргэдийн асуудал. Энэ бол маш ноцтой түвшинд хүрсэн. Манай БГД дээр энэ бүүр хэдэн жил үргэлжилж байгаа. 2012-2016 онд намайг гишүүн байхад энэ асуудал байсан. Одоо энэ асуудал үргэлжилж байгаа.

Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр энэ хуулиар нэлээд юмыг нь зохицуулах юм байна аа. Энэ бол маш чухал аа.

Дээрээс нь энэ барилгын компаниуд хугацаандаа үүргээ биелүүлдэггүй. Дээрээс нь давхар зардаг бүүр ингээд зарим нь бүүр залилангийн шинжтэй болчихсон. Зарим нь бол яах вэ байрыг чинь нэг хэзээ нэгэн цагт өгнө гэхдээ мөнгийг нь эргэлдүүлдэг нэг ийм бүүр ингээд мэргэшээд энэ компаниуд чинь бүүр ийм болчихжээ. Тэгэхээр энэн дээр энэ бүх зүйлийг оруулж өгсөн үү гэдгийг хармаар байна.

Дээрээс нь энэ залилдаг барилгын компаниуд чинь залилж залилж байгаад компанийнхаа нэрийг солиод дахиад залилаад эхэлдэг. Энийг тэр бүртгэл дээр чинь хар жагсаалт гээд гаргах юм байна уу гэдгийг асуух гэсэн юм.

Дээрээс нь эхлээд ингээд барилга захиалахад ингээд нэг эскиз зураг хүмүүст танилцуулдаг шүү дээ. Ногоон байгууламж, эндээ тоглоомын талбай, энэ хотхонд тэдэн байшин байна гээд. Тэгэнгүүтээ айлууд оронгуут дахиад нөгөө хотхонд нь 5 биш 10 бай байшин болоод явчихдаг. Тоглоомын талбай нь нэг жижигхэн юм болдог. Тэгэхээр энийг тэр бүртгэлийн эскиз зураг нь тийшээ ингээд орж байгаа юу?

Энэ өөрөө их чухал асуудал байгаа юм. Энийгээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх энэ анх захиалга өгөхдөө сайхан амлаж байсан юмнууд нь зөрчих юм бол хариуцлага хүлээдэг юмнууд байна уу гэдэг зүйл байгаа.

Яагаад гэхээр манай БГД дээр энэ байшинг хүлээсэн хүмүүс маш их хохирсон. Өргөдлийн байнгын хороон дээр ирсэн. Энэ хүмүүс ямар байдалд орсон байдаг вэ гэхээр 1 дүгээрт олон жил амьдрах газаргүй явсан.

Хоёрдугаарт зарим нь машиндаа амьдардаг. Энэнээс болж нөгөө захиалга өгсөн хүн буруудаад гэр бүл салдаг, амиа хорлосон тохиолдлууд ч байгаа. Сэтгэл санааны хохирол маш олон хүн нь нас барсан гээд ингээд бүүр хохирол нь үнэхээр их байдаг юм аа. Тэгээд энэ хүмүүс хөөрхий ингээд гудамжинд олон жил яваад сая Өргөдлийн байнгын хороон дээр энэ асуудлыг нь ингээд сонсоод ажлын хэсэг гараад тэгээд Сайнзориг гишүүн ингээд хууль санаачлаад орж ирж байгаад би их баярлаж байна. Энэ асуудлуудыг нь шийдээсэй гэж.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд асуух уу? Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Одоо байгаа энэ асуудлуудыг энэ хуулиар шууд зохицуулна гэж иргэдэд хэлэмгүй байна. Энэ бол цаашдаа хийх гэрээн дээр. Зүгээр барилгын дуусаагүй барилга дээр захиалга өгчихсөн байгаа этгээдүүд энэ хууль батлагдаад хүчин төгөлдөр болвол барилгын компанитайгаа яриад гэрээндээ өөрчлөлт оруулаад ч юм уу энийгээ баталгаажуулах арга хэмжээ энэ тэрээ хийж болно. Одоо бас тодорхой нээлтүүд байгаа боловч энэ гэрээний талууд бас тохиролцоод шинэ хууль, эрх зүйн орчны дагуу гэрээгээ тодотгоё гэвэл боломж нь Иргэний хуулийнхаа хууль, хувьцаа хэрэглэх зарчмын дагуу байж байгаа боломжтой байгаа. Энэ хүрээндээ явна. Ер нь зүгээр энэ орон сууцын асуудлаас болоод хохирч байгаа асуудлыг 3 янзаар байна лээ.

Нэгдүгээрт яг таны хэлж байгаа огтоосоо бүүр анхнаасаа залилан. Зүгээр макет үзүүлж байгаа, хуурамч бичиг баримт үзүүлж байгаад ийм зүйл.

Хоёрдугаарт яг барилгын зөвшөөрөлтэй боловч нөгөө компанийн одоо өөрсдөөс нь болоод янз бүрийн шалтгаанаас болоод барилгын ажил нь санхүүжилтээсээ болоод ч юм уу таг гацчихсан, газрын маргаанаасаа болоод таг гацчихсан ингээд явж байгаа юм.

Дээрээс нь нэг бүлэг асуудал дахин төлөвлөлтийн асуудал. Дахин төлөвлөлтүүдийг нэг компаниудад ингээд өгчихсөн. Ийм 3 асуудлаас ингээд иргэд бас 1 ерөнхий байдлаараа байгаа. Тэгээд энэ ХЗХ-ны асуудал шиг болгочихгүйн тулд л манай Өргөдлийн байнгын хороо анхаарч яах ёстой вэ гэдэг зүйл харзнаад байх шиг байна. Тэгээд энэ дээр бас манай хуулийн байгууллагуудын жоохон зарим үзэмжийн асуудлууд ч орсон тохиолдлууд байдаг. Илэрхий улаан цагаан залилангийн гэмт хэргийн шинжтэй байж байхад чинь гэрээ байна гээд явдаг цаг алдуулдаг юмнууд байна. Ийм зүйлүүд ингээд байгаа учраас энэ хууль эрх зүйн орчны юмнуудыг анхаарах цаашдаа ер нь энийг төрөөс хуулийн байгууллагаар асуудлаа шийдүүлэх гэсэн барилгын компаниудын нэгдэл буюу энэ танхим дээрээ мэргэжлийн барилгын компаниуд өөр өөрсдийнхөө стандартыг тогтоож хамт энэ зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүстээ бас энэ өөрсдийн нөлөөллөө үзүүлэх ёстой байхгүй юу. Энэ компаниуд нь иргэдийг хохироогоод байна гэдгээ шударга компаниуд нь сайн компаниуд нь хэлж байх ёстой. Ингэж байж энэ зах зээл

хамгаалагдана. Энэ бол энэ хууль дээр яригдах зүйл биш. Давхар зардаг асуудал бол би Өргөдлийн байнгын хорооны хэлэлцүүлгийг сонсоод сууж байсан эмзэглэмээр юм байна лээ. 3 гэдэг бол бараг л нормал ч юм шиг. Заримыг нь 5 ч зарчихсан тохиолдол байна. Жишээ нь давхар зарчхаад тэгдэг юм байна лээ. Гурвууланг нь дуудаж уулзаад барилгын материалын үнэ болон ийм юмнууд өссөн учраас нэмж мөнгө өгвөл алинд нь мөнгө өгсөнд нь өгнө гээд явдаг. Нөгөө 2 дээр нь болохоор шүүхдээд аваарай гэдэг. Шүүхдээд явахаар 2, 3 жилийн дараа хүний мөнгийг зүгээр эргэлдүүлэх гээд байна шүү дээ өгнө өө л гэдэг. Тэгээд энэ чинь өнөөдрийн өгч байгаа 100 сая төгрөг 2, 3 жилийн дараа ямар үнэ цэнтэй болох вэ гэдэг зүйлээ ярих юм бол энэ барилгын компаниуд чинь зүгээр хүний мөнгийг эргэлдүүлэхийн тулд давхар гэрээ, давхар зараад байгаа байхгүй юу.

Тэгээд дараа нь ийм юм. Тэгэхээр энэ уг нь анхнаасаа залилан болох.

Д.Цогтбаатар: Минут гүйцээгээд өгье. Наадах чинь хэлэх ёстой үгнүүд хэлэгдээд байна. Протоколд үлдээе.

П.Сайнзориг: Энэ гэрээн дээр барилгын компаниудыг үүрэгжүүлээд өгчхөж байгаа. Анхнаасаа энэ 9 тоот дээр захиалга аваад ийм урьдчилгаа төлбөрийг нь авчихсан бол энийг улсын бүртгэл дээр бүртгүүл. Энийгээ мэдсээр байж одоо энэ үүргээ зөрчиж, дахиад захиалга авна гэдэг бол цаашдаа харин залилан мэхлэх гэмт хэргийг зүйлчлэх гэдэг юм уу иргэдийг төөрөгдүүлж 2 дахь, 3 дахь гэрээг хийсэн гэдэг байдлаараа энэ Иргэний хуулиараа явсан ч гэрээг хүчин төгөлдөр бус тооцуулах ер нь залилан мэхлэх гэмт хэргийн юм явж байгаа.

Таны асууж байгаа асуудлууд буюу ямар ямар мэдээллүүд ил болгох гэхээр нөгөө энэ захиалга авсан мэдээллээс гадна барилгын баригдах газрын эрхийн бүртгэлийн мэдээлэл, кадастрын код, барилгын батлагдсан загвар зураг, батлагдсан зураг, төсөв, техникийн төсвийг баталгаажуулсан шийдвэр, тэдгээрийн өөрчлөлтийн талаар мэдээлэл ил тод нээлттэй болно оо. Яг нэг гоё макет үзүүлээд энд зогсоолтой энд макеттай гэж байгаад эхний барилгуудаа зарж захиалгаа авч дууссаны дараа энэ дээр нь дахиад нарыг нь хаагаад ногоон орон сууц биш хүрэн орон сууц болгоод өмнөх орон сууцуудаа захиалга аваад иргэдийг төөрөгдүүлээд.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ ингээд давхардахгүй энэ бүх зүйлүүдийг нь би ойлгочихлоо. Энэ дээр нэг хувь хүний нууцын асуудал байх уу? Одоо жишээлэхэд нэг хүн нэг газар ингээд нэг байр захиалчихсан тэрийг нь ингээд хэн дуртай нь ороод үзэх боломжгүй ч юм уу нэг тэр асуудлыг зохицуулах энэ чинь нэг эмзэг л асуудлын нэг л дээ.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Маш чухал асуулт байна аа. Тэгэхдээ энэ зөвхөн Одонтуяа гишүүнээ эрхийн төлөв л нээлттэй байх юм. Өөрөөр хэлэх юм бол яг Сайнзориг гэдэг нэр гарч ирэхгүй. Тэр 9 тоот нөгөө өмнөх жишээг л ярь 20 айлтай тэр нэг орцтой орон сууцын 9 тоот дээр би захиалга өгчихсөн захиалгатай л гэдэг эрхийн төлөв л гарна. Эсвэл Банкны барьцаанд байна гэдэг ийм нэхэмжлэлийн шаардлагууд байгаа гэдэг ч юм уу ингээд эрхийн төлөв гарна уу гэхээс биш яг

Сайнзориг, Пүрэвжавын Сайнзориг ч гэдэг юм уу одоо яг Салдангийн Одонтуяа гэдэг нэр гарахгүй. Ямар ч байсан ийм зүйлүүд нь нээлттэй байхгүй л гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Дийлэнх асуултууд давхцаж байгаа. Тэгээд асуулт давхацсан учраас ганц нэг асуугдаагүй асуултуудыг асуумаар байна. Ажлын хэсгээс асуухад энэ Англи, Австралийн чиглэлийн хууль тогтоомжуудыг хэр судалсан бэ? Жишээлбэл зарим орнуудад бол ердөөсөө энэ байр урьдчилж захиалах энэ асуудлыг заавал агентаар дамждаг. Иргэн хүн тэ үйлдвэрлэгч буюу барилгын компанитай шууд харьцдаггүй. Яагаад вэ гэхээр зэрэг эрх зүйн хувьд маш ялгаатай нөхцөл байдалд байгаа улсууд байхгүй юу. Барилгын компанийн этгээдүүд бол өөрсдөө хуулийн мэдлэгтэй чадвартай улсуудыг хөлслөөд авах бүрэн боломжтой. Гэтэл өнөөдөр зүйрлэвэл Солонгост өдөр шөнөгүй ажил хийж байгаа нөхдүүд маань 100 хувийн захиалга өгчихвөл ингээд арай хямдханаар авч болж байна аа. Тэртээ тэрэнгүй харийн нутагт ажиллаж байгаа учраас нэг жилийн дараа 2 жилийн дараа ирээд байрандаа орчихъё гэж байгаа улсуудад бол эрх зүйн судалгаа хийх тийм боломж бололцоо байхгүй.

Тэгэхээр энэ шийдэл гарцыг та бүхэн маань тооцсон уу? Тэрэн дээр ямар гаргалгаа гарц харсан бэ?

Хоёрдугаарт энэ гэрээний тулгасан гэрээнүүд аягүй их өндөр хийдэг. Барилгын компаниуд ялангуяа ингээд 100 хувийн урьдчилгаа захиалга өгчихье 50 хувийг өгье гэх юм бол заавал нөгөө матрицаа дагаад анхны банкны хүүнээсээ хямд нөхцөлөөр зээл авах гэж байгаатай ялгаагүй анхны хөрөнгө оруулалтаа босгочихдог. Тэгээд тэр хөрөнгөө яг тухайн үл хөдлөх хөрөнгөдөө оруулж байна уу үгүй юу гэдэг дээр хяналт байхгүй. Өөр барилга руугаа, өөр төсөл рүүгээ, өөр бүр сайн ярих юм бол бизнес рүү шилжүүлэх боломж байдаг. Энэ дээр хяналт яаж зохицуулж байна вэ? Тэгээд иргэн компани 2-ын харилцаанд ороход заавал компанийн үлгэр болсон темплэйт болсон тэр гэрээний нөхцөлийг тулгадаг. Жишээгээр хэлэх юм бол жишээгээр би ингээд захиалга өгчихлөө цуцалъя гэхээр зэрэг заавал дараагийн захиалагч таны байрыг авсан нөхцөлд таны мөнгийг ийм ийм нөхцөлөөр олгоно оо ч гэдэг юм уу. Тэгэнгүүт нөгөө захиалагчийн эрхийг зөрчсөн маш олон ийм зүйл заалтууд байгаад байдаг. Тэгээд улсын субъект оролцоод бүртгэл яг үнэндээ хэлэх юм бол маш хүнд сурталтай байгууллага шүү дээ. Тэгээд маш их алдаатай. Үргэлж дандаа үсэг, тоо алдаж байдаг газар. Тэгээд энэ бол би жоохон нэг тийм санаа нь зөв боловчиг жоохон сийрэг байна дахиж сайн судлах хэрэгтэй. Тэгээд зөв жишгийг ялангуяа үнэхээр тэр нэг минутаа авчихъя тэгэх үү?

Х.Баасанжаргал: Нэмэлт нэг минут гишүүний микрофоныг нэмж өгөөрэй. Пүрэвдаваа гишүүний микрофон дээр нэг минут нэмж өгөөрэй.

Д.Пүрэвдаваа: Тэгээд урьдчилсан зохион байгуулалтаар* шуналын сэдлээр хандаж байгаа нь бол би нийт энэ дуусаагүй барилга чинь та нарын материал дотор 10 мянга гэж байхад гомдлын асуудал чинь 1 мянга орчим л юм байна шүү дээ. Зөв үү? Тэгэхээр ингээд нөгөө харахаар зэрэг бас эдийн засгийн нөхцөлөөсөө, дэд бүтцийн хүрэлцээтэй нөхцөлөөсөө болоод үнэхээр тэрийгээ оруулж чадахгүй байгаа улсууд байгаа байх. Тэгэхдээ энийг ингээд та бүхэн маань ялгаж салгасан уу? Хэр сайн судалгаа хийсэн юм бэ? Хэдий би бол эндээс харахад бол барилгын

чиглэлийн хүмүүсийн санал ер нь бараг тусгагдаагүй юм биш үү. Хариулт авъя. Тодруулна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би агентаар дамжуулах энэ асуудлыг Өргөдлийн байнгын хороон дээр ярьсан. Би бас Номинчимэг даргатай уулзахад уг асуудлыг тавьсан. Хамгийн уг нь сайн хувилбар байгаа.

Дээрээс нь манай барилгын компаниуд дээр энэ даатгалын систем орж ирдэггүй учраас яг төрийн байгууллагууд ашиглалтад орох ажлыг хариуцаж авдгаас эхлээд л асуудлууд үүсэж байгаа. Үнэхээр цаашдаа явъя гэвэл уг нь даатгалын системээ оруулж ирээд даатгалын компани, зохиогч, зургийн зохиогч нь өөрөө хяналтаа тавьдаг энэ механизм ороод ирвэл ийм чанартай чанаргүй хүн өөрийнхөө зургаар тийм чанаргүй барилга оруулахыг хэн ч хүсэхгүй байхгүй юу.

Дээрээс нь даатгал ороод ирвэл зүгээр юмыг даатгаад суухгүй шүү дээ. Яг үнэн чанар тэр зүйл дээр нь энэ А зэрэглэлийн барилга уу, В нэмэх барилга уу, В барилга уу гээд энэ жишээ нь Японы стандартаар ингээд шийднэ. Тэгээд энийг одоогоор манайх хүлээж авах боломж энэ тэр нь жоохон хомс байна. Би Номио даргатай ингээд санал цуглахад би болгоомжлол хэлсэн. Номио дарга ч өөрөө тэгж бодсон. Энийг бид 2 ярих юм бол бараг нөгөө юу билээ нэг хэдэн үл хөдлөх хөрөнгийн ангид агентуудыг дэмжсэн хэрэгт орох юм байна лээ. Тэгэхээр бас хууль санаачлагчийн хувьд та бас энэ асуудлыг ултай суурьтай судлаад тэр хэсгийг нь оруулж ирж болох байх.

Би бол одоо зүгээр байгаа хэмжээндээ ямар ч байсан гэрээ контракт байгуулахаасаа өмнө нягталж үзэх тэр боломжийг нь ямар ч байсан эхний ээлжинд олгоё. Цаашдаа ер нь зүгээр хүн барилгын компанитайгаа биш ажил үүргээ зөв хуваарилаад яг энийгээ зөвхөн үл хөдлөх хөрөнгийн зуучлагч буюу рийлтрүүдээр дамжуулж захиалгаа авах ёстой гэдэг бид хэд стандартыг нь тогтоон хууль гаргаад өгвөл болно. Тэгээд энэ дээр бас нэг юм дутагдсан нь даатгал орж ирэх ёстой.

Хоёрдугаарт үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг зах зээлийн зарчмаар нь тогтоодог арга зүйд сурчхаад бид нар энэ явах юм байна лээ. Одоо болохоор энийгээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа шүү дээ. Тэгээд аль болохоор багаар үнэлүүлнэ гэрээний үнээр үнэлүүлнэ гээд бүгд өөрсдөө аашилдаг. Татвараас зугтахын тулд транзакшны костоос зугтахын тулд. Тэгээд ийм байгаа учраас энэ зах зээл одоо яг таны хэлж байгаа саналыг одоохондоо хүлээж авах тэгэхдээ би үгүйсгээгүй. Судлах ёстой юм байна лээ. Зөв. Ийм зүйл байгаа юм аа.

Хоёрдугаарт ер нь өөр төсөл рүү мөнгөө оруулчихдаг гээд үнэн. Энэ манай татварын хуультай ч холбоотой. Яагаад гэхээр татвар ААНОАТ 10 хувь байдаг. Тодорхой орлого үнийн дүнгээс шалтгаалаад ирэнгүүт 25 руу явчхаж байгаа юм. Тэгээд 25-ыг төлөх үү? Барилга гэдэг үнийн дүн ихтэй. Яг ийм зүйлээсээ болонгуутаа 10 хувийн татвар луу орохын тулд барилгын компаниуд нь жижгэрдэг. Яг бодит байдлаараа өнөөдөр барилгын зах зээл дээр монопол явж байгаа компаниуд ч гэсэн 70-аас 80 компанийн задаргаатайгаар энэ бизнесийг хийж татвараас зайлсхийдэг юм байна лээ. Өндөр татвар төлөхгүйн тулд шүү. Би зугтаж байна гэж хэлэх гээд байгаа юм биш. Ийм байгаа юм аа. Тэгэхээр бид хэд энэ татварын бодлогоороо аваачаад энэ бизнесүүдийг хэт жижиглэдэг. Жижгэрснээсээ

болоод хэрэглэгч цаана нь хохирдог ийм зүйлүүд байгаа. Тэгээд энийг 2 талдаа байгаа үнэхээр барилгын компаниудын буруу зүйлд оруулаад ч юм уу эсвэл ийм зүйл явбал энэ өөр хэрэг.

Нөгөө талдаа барилгын компаниудын санхүүгийн чадавх муудаад ирвэл энэ хуулийн асуудал гэхээс уг нь дампуурлын хуулийг гаргаж төлбөрийн чадваргүй ажиллагааг яаралтай явуулж хохирлыг томруулахгүйгээр шийдэх ёстой байхгүй юу. Манайд тэр хуулийн юм баталж өгдөггүй юм. Тэгээд бүх юм дууссаны дараа л асуудлуудыг цагдаагаар шийдүүлэх гээд л залилан мэхлэх гэмт хэргийн хүрээнд шийдэж байгаад л яаж ийж байгаад л 2 чихнээс өөр юм байгаа гээд л хөөцөлдөөд байдаг байхгүй юу. Асуудал томрохоос нь уг нь дампуурлын гэдэг юм уу төлбөрийн чадваруудын ажиллагаа явуулаад гүйцэтгэх захирлыг нь сольж байгаад гэрээний хэрэгжилт хөрөнгө мөнгө зугтаалгаад байгаа бол тэрийг нь шүүхийн оролцоотой шийддэг байхгүй юу. Манайд даанч энэ бизнесийн соёл байхгүй.

Тэгээд Номинчимэг гишүүн энийг ахлаад явж байгаа намрын чуулганаар энэ хуулиудаа ямар ч байсан сайжруулж гаргах байх гээд итгэж байгаа. Ингэвэл энэ шийдэгдэнэ. Тэгэхээр энэ хуулиуд болоод байгаа зүйл биш байгаад байгаа юм. Маш олон хуулиуд ийм уялдаатай байна.

Хоёрдугаарт энэ хэрэглэгчийн гэрээний асуудал дээр шууд тулгадаг үнэн. Ер нь топ 5 хэрэглэгчийг хохироодог энэ асуудал захиалгын гэрээнүүд байгаа. Энэ захиалгын гэрээн дээр бараг уншаад л зурж байгаа даа. Бараг ингэж тэгийг гэж өөрчлөх ямар ч боломжгүй л байгаад байгаа, тулгачихдаг. Тэгээд энэн дээрээс болоод уг нь хэрэглэгчийн гэрээний хуулийг бас нэг.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Ингэе, хууль санаачлагч Сайнзориг гишүүнээ мэдэлгүй л яах вэ хууль зүйн хувьд асар туршлагатай, төрийн албанд олон жил ажилласан, олон хууль санаачилсан, олон ажлын хэсэгт орсныг мэднэ ээ. Гэхдээ би нэг зүйлийг яг ингээд олон арван байшин ашиглалтад оруулчихсан гэж би яг Сайнзориг гишүүнийг би мэдэхгүй байхгүй юу. Тэгэхээр яах вэ гэхээр зэрэг энэ барилгын салбарын одоо энэ чинь нэг бид нар зах зээлийн нийгэмд шилжээд 30 гаруй жил болчихлоо, хувийн өмчтэй болоод удчихлаа. Тэгээд энэ хувийн өмч гэдэг юмыг чинь бид нар тодорхой хэмжээнд хамгаалдаг. Тэрийг жишээлбэл зөвөөр хардаг ийм байх ёстой. Тэгээд мэргэжлийн улсууд нь уул нь бол яг нарийн тоо ярьдаг, шийдэл ярьдаг байхгүй бол улс төржсөн үгээр бид нар нийгэмд хариулт өгч болохгүй шүү. Окэй. Тэгээд би дахиад нэг тоонууд л асуумаар байгаа юм.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн миний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Уг хуулийн төсөлтэй холбоотой Өргөдлийн байнгын хороон дээр тал талын төлөөллүүдийг яагаад Номинчимэг гишүүн надад яг албан ёсны Өргөдлийн байнгын хорооны зөвлөмж мэдээллүүдийг өгсөн. Энэ дээр юмнууд нь тоо мэт байгаа зүйлүүд байгаа. Хуульчдын холбоон дээр бид хэд бас хэлэлцүүлэг хийсэн. Зөвхөн энэ Хуульчдын холбоон дээр хийсэн хэлэлцүүлэг дээр хуульчид байгаа гэж битгий ойлгоорой. Яг энэ гэрээний асуудал байхгүй юу. Барилгын асуудал гэдэг чинь иргэдээс хэрэглэгчийн гэрээний асуудал. Тэгээд яг энэ барилгын компаниудын хуульчаар ажиллаж байгаа. Дээр нь энэ иргэдийн хохирсон хэргүүдийн кэйс дээр өмгөөлөгчөөр ажиллаж байгаа ийм залуучууд оролцож

хуульчдын холбоон дээр бид хэлэлцүүлгүүд хийж, хаана нь ямар асуудлуудыг нь ухварлаж өгвөл болох вэ гэдэг зүйлүүдийг нь энд тусгаж өгсөн юм аа.

Тийм учраас Пүрэвдаваа гишүүндээ би нэмэлт мэдээллийг өгөхөд ийм байна. Бүүр тогтолцооны хувьд тэр агентаар дамжуулж захиалга авах энэ тэрийг би хувьдаа дэмжиж байгаа. Тэгэхдээ би бол бас энэ дээр ерөнхий мэдээллүүдийг авч Номинчимэг гишүүн энэ Өргөдлийн байнгын хороон дээр ч ярьсан зүйл байхгүй юу. Яригдсан юм байна лээ. Тэгээд өнөөдөр энэ зүйлүүдийг хийхийн тулд.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүн болсон уу хариулт хангалттай юу? Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Энэ манай Сайнзориг гишүүн их чухал хууль оруулаад ирж байна. Тэгэхдээ би Пүрэвдаваа гишүүнтэй л их дөхүү саналтай байна даа. Хөөш энэ ер нь Засгийн газар байгаа билүү Монгол Улсад. Энэ чинь манай иргэдийн маш их олон иргэний эрх ашгийг хөндсөн. Би бүүр хэлье дээ. Гадаадад ажиллаж тэндээсээ явуулсан мөнгө, хашаа байшингаа зарсан мөнгө, зээл айл амьтнаас цуглуулсан мөнгө, байшингаа зараад чиний байшинг би нураачихъя. Чи энэ айлын энэ байранд түр зуур түрээсээр амьдар гэж хэлээд амьдруулж байгаад. Түрээсийн төлбөрөө төлөхөө болиод нөгөөдөх нь шүүхдэлцээд. Үгүй ерөөсөө энэ бол галзуу ийм солиотой л ийм ажиллагаа шүү дээ. Тэгээд энийг цэгцэлж янзалъя гэдэг ийм санал санаачилга гаргаж байгаад нь би баярлаж байна. Хөөш тэнд хэн байна. Батдэлгэр байна уу, Батзориг байна уу цагдаагийнхан. Би СХД дээр тэр кид апартамент гэдгээс болж бүүр дагуулж очиж уулзуулсан. Цагдаагийн дарга дээр дагуулж очоод уулзуулаад эд нар нэг жаахан хөдлөнгүүт байшин нь овоо хэдэн давхар явж байгаад л тэгээд зогсчихсон. Энэ бол өнгөрсөн зүйл. Одоо энэ ирээдүй цаг дээр яаж ийм юмнаас ангижрах вэ гэж. Тэгэхээр би бол юу гэж хэлж байна вэ гэхлээр энэ орон сууцыг Орон сууцын захиалга авах тухай хууль л гаргамаар байна. Бүртгэл байна Сайнзориг гишүүн. Таны энэ хэсэг бол нэг хэсэг нь. Тэгэхдээ энэ орчин үед санхүүжилт гэдэг юмгүйгээр бол хоосон бүртгэл явахгүй. Тэгэхээр яаж мөнгө авах юм? Одоо чинь ямар асуудал үүсчхээд байгаа юм. Амьтны баахан мөнгө авчхаад ер нь залилан хийж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ залилангаас урьдчилан сэргийлэх хууль л баймаар байгаа юм. Батдэлгэр залилангаас сэргийлнэ гээд та нар яриад байдаг. Энэ тийм чиглэлийн хууль баймаар байна. Ялангуяа орон сууц дээр. Одоо би мэдэхгүй байна л даа. Энэ дээр би бол Засгийн газар ажилламаар байна. Сайнзориг гишүүнийхээ энийг зогсоочихоор бас хэцүү. Зогсоохгүй гэхээр очоод өрөөсөн хаа л явж байна. Энэ нэг өрөөсөн гар л яваад байна. Нөгөө гар нь, нөгөө хөл нь, зүрх нь, тархи нь систем ерөөсөө энэ саяын Пүрэвдаваа гишүүний хэлж байгаа шиг тэд нар маань эд нар ажиллахгүй шүү дээ. Энэ чинь өөрөө цогц асуудал байхгүй юу. Маш олон талын сонирхол орж байж.

Тэгэхээр ингэж янзалж болохгүй юм уу? Би яаж санал өгөхөө мэдэхээ байчихлаа. Энэ чинь зориулалтын бус зарцуулж байгаа шүү дээ. Тэгээд би өөрөө зүгээр дугуй зохион бүтээгээд сууж байна л даа. Нэг тэр агент маягийн системээр дамжих ёстой. Тэгээд тэр рүү порц порцоор мөнгө өгөх ёстой. Порцоор шүү эрсдэлийг багасгаж. Тэгэхгүй бол ингээд хүний хашаа байшин, байшин зарсан мөнгийг аваад тэгээд ерөөсөө ингээд хэдэн жилээр нь байшин нь босдоггүй өөр юманд эргүүлээд. Тэгээд манай хууль хяналтын байгууллага дээр хэцүү юм.

Д.Цогтбаатар: Гүйцээх үү? Алтанхуяг гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Н.Алтанхуяг: Би цагдаагийн байгууллагад ч хэлсэн. Дүүрэг дээр нэг хэрэг үүсчихсэн ч явж байх шиг, энэ төвд нь нэг хэрэг үүсчихсэн ч явж байх шиг. Ингээд ёстой адгийн зарга, дээр үед 10 хоног байсан юм байна лээ. Одоо адгийн зарга 10 жил болж байна шүү дээ. Энэ хүний мөнгө авчхаад ингэж 10 жилийн зарганд оруулна гэдэг бол Монгол Улсад засаг байхгүй, төр байхгүй гэсэн үг шүү.

Тийм учраас энэ дээр хууль санаачилсан гишүүнийгээ би бол дэмжиж байна. Тэгэхдээ энэ нэг хүний хийдэг ажил биш. Энэ Монгол Улсын засаг гэж байдаг бол засаг бүх шугамаараа ажиллаж оруулж ирэх ёстой хууль. Тэгэхдээ хугацаа алдаж болохгүй. Тэгэхээр яаж болдог юм энэ Сайнзоригийнхоо хуулийг явуулчихаад тэгээд Засгийн газарт чиглэл өгч болдог билүү энийг ингээд боловсруулаад оруулаад энэ асуудлыг ингэж хий гээд. Би нэг ийм 2 талтай явбал их зөв болно оо л гэж бодож байна. Хүний хийсэн юмыг үгүйсгэмээргүй байна. Тэгэхдээ бусад харилцаануудыг нь хаямааргүй байна. 30 хувь байшин.

Д.Цогтбаатар: Нэг минут гүйцээгээд өгье.

Н.Алтанхуяг: Нэг дутуу барьсан байшин бүртгэнэ гээд. Тэгэхээр ор хоосон газрын хэрүүл нь Алтанхуягийн газарт Номинчимэг хөрөнгө оруулагч ингээд л бөөн хэрүүл болдог юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр ийм юман дээр иргэн очиж харилцах бол тэгээд л бид нар улс биш л гэсэн үг. Тэгээд энэ харилцааг зөв болгомоор байна. Агент юм уу, агентлаг юм уу мэдэхгүй. Нэг тиймэрхүү хувийн маягийн юмнуудаараа дамжаад явах ёстой. Нөгөөдүүл нь өөрөө даатгалынхаа тогтолцоонуудыг хангасан байх ёстой. Тэрэн дээр нь төр засаг оролцдог. Энэ нэг ийм зах зээлийн маягийн болговол яасан юм? Пүрэвдаваа ер нь хаанаас уншсан юм эсвэл үзсэн юм уу эсвэл олон байшин барьсан юм уу? Чи ер нь ажлын хэсэгт нь ормоор юм байна. Тэгээд хэдүүлээ тал талаасаа хамтарч байгаад намар гэхэд хуультай болгож өгмөөр байна. Ийм л хүсэл байна надад.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Алтанхуяг дарга маань угаасаа юмыг жоохон томхон хардаг хүн дэмжиж байгаад баяртай байна аа. Тэгээд энэ хуулийн дагуу бас Алтанхуяг даргын хэлж байгаа шиг Засгийн газарт тодорхой хэмжээний цаашдаа бүр сууриар нь шийдэх чиглэлийг нь өгч болно. Энэ бол өнөөдрийн явж байгаа Иргэний хуулийн болоод Барилгын хууль тогтоомжийг ер нь шийдэж болж байгаа юм. Ер нь барилгын хууль, тогтоомж дээр зургийн автор өөрөө бас энэ захиалагчийн хяналтыг тавих юун дээрээ бас ямар үүрэг рольтой үүрэг оролцоотой оролцох вэ гэдэг зүйл. Даатгал яаж орж ирэх вэ? Энэ барилгын компаниуд нь зөвхөн юу гэдэг юм. Иргэдийг төөрүүлээд байгаа байхгүй юу. Нөгөө 70, 30 компаниараа энэ тэдээр нь аваад, энэ тэдээр нь ав. Номинчимэг гишүүний бас Өргөдлийн байнгын хороон дээр ярьж байсан Пүрэвдаваа даргын хэлж байгаа шиг зөвхөн үл хөдлөх хөрөнгийн эйнчин дээр дамжуулж ав гэдэг энэ хуулийг бодлогын хүрээнд гаргавал энэ асуудлуудыг тэгж шийдэж болно.

Тэгэхээр энэ ярьж байгаа зүйлүүд дээрээ бас үүрэг даалгавар чиглэл өгөөд Засгийн газартайгаа харилцаж болох байх гэж бодож байгаа юм. Энэ бол харин өнөөдөртөө ямар ямар цаашдаа ийм зүйлүүдийг гаргахгүй байх газрын гэдэг юм уу ус дулаанд хангагдах нь мэдэхгүй барилга дээр захиалга өгөхөөс ямар ч байсан

хаалт болж байгаа. Харин энэ хариуцлагатай явж байгаа барилгын компаниудаа хамгаалж байгаа. Дээрээс нь барилгын компаниуд ч гэсэн бизнесийн соёл төлөвлөлтөө хийх бололцоог нь олгож өгч байгаа. Энэ тодорхой болгож өгч байгаа хууль байгаа юм. Тэгээд ямар ч байсан иргэд бол мэдээлэлтэй танилцана гэдэг бол эрсдэлээ бас үзэх гэрээн дээрээ наад асуудлуудаа нягтлаад харах энэ бололцоог олгоод явах нь зүйтэй байгаа гэж би хэлмээр байна.

Барилга орон сууц захиалгын гэрээ хуультай ч гэхээсээ илүүтэй Алтанхуяг даргаа ер нь бол энэ Иргэний хуулийн л асуудал юм байгаа юм л даа. Хүн мөнгөө өгөөд тодорхой бүтээгдэхүүн авах гэж байна шүү дээ. Энэ угаасаа хуультай. Тэгээд манай иргэдийн ухамсар эрх зүйн соёл боловсрол, угаасаа энэ гэрээний тэгш байдлын зарчим байдаг боловч иргэд дээр очихоор дараагийн хүн чинь авах гэж байна чи зурвал зур гээд л явчихдаг байхгүй юу.

Тэгэхээр бид хэд ийм байдал руу байгаа учраас бас иргэдийгээ хамгаалж өгөх нь зүйтэй байгаа юм аа. Тийм учраас Иргэний хууль болон холбогдох хуулиуд дээрээ энэ иргэдээ хамгаалсан энэ зохицуулалтуудыг хийж өгч байж л энэ асуудлуудыг ингээд цаашаа томруулчихгүйхэн шийднэ. Өмнөх асуудал дээр бол энэ нэг их тийм шууд нөлөө үзүүлнэ гэж би хэлж чадахгүй ээ. Тэр асуудлууд бол зарим зүйлүүд хүнд болчихсон байгаа. Тэгээд би бас түрүүн хариултдаа хэлсэн. Яах аргагүй энэ залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг бид нар заримдаа худлаа үгүйсгэж үзэмжээрээ шийдэж байгаа асуудлаас болоод бүр томруулж байгаа нь ч юм байна. Тэр компаниуд нь төлбөрийн чадваргүй асуудалд орчхоод байхад бид хэд ч угаасаа нөгөө тэр хууль нь муу учраас тэр компани бүх хөрөнгөө зайлуулж нууж шилжүүлсний дараа ингээд одоо яах юм шүүхээр явна биз гээд ингээд мухардчихаад байгаа зүйлүүд байгаа байхгүй юу. Энэ иргэний хуулийн орон сууц захиалгын авч байгаа хууль гэхээсээ илүү тэр Эрүүгийн хуулийг яаж хэрэгжүүлж байгаа юм.

Дээрээс нь төлбөрийн чадваргүйдлийн, тэгээд яах вэ барилгын болоод даатгалын хуулиудын зарим суурь концепцыг хөндөх үү үгүй юу гэдгээс ихээхэн шалтгаална. Би жишээ нь энэ орон сууцын гэлтгүй ер нь барилгыг хүлээж авах комиссын асуудлыг даатгалын компанид л хариуцуулчихмаар байгаа байхгүй юу. Тэгээд даатгал үнэлчихнэ, даатгана, даатгахгүй ийм төлбөрөөр үнэлнэ. Наадах чинь үнэ цэнтэй барилга байна уу, үгүй байна уу гэдгийг цэвэр мэргэжлийн хүмүүс чинь зүгээр л хэлээд өгчихнө.

Манайд болохоор улсын комисс гээд нэг хэдэн төрийн албан хаагчид яваад зангиа шахаад тэр тоосон дунд гүйдэг байхгүй юу. Тэгээд л авдаг юм шиг байгаа юм. Тэгээд л за боллоо. Тэгээд л 3 жилийн дараа нөгөө барилгын сан эхнээсээ зад үсэрдэг, шалаа сольдог, доод айлынхаа засварыг хийдэг, хаалга үүд нь яаж байдаг. Бараг нарийн яривал тэгээд метр квадрат нь сайн яривал хүрэхгүй. Ийм л зүйл байгаа. Тэгэхээр бид хэд иргэдийнхээ өмчийг хамгаалахын тулд яг энэ явж ирэх зах зээлийн зарчим буюу тэр даатгалын систем тэр зургийн авторыг оролцуулж ирж хариуцлага хүлээдэг гэдэг хяналтаа тавьдаг тэр зүйл рүү нь оруулж ирэхгүй бол зургийн автор дараа нь би мэдэхгүй. Тэгээд би зургийг нь зурсан, барилгын компани зурсан. Тэгээд л шийдчихсэн л юм байна лээ шүү дээ гээд л. Ингээд л яваад байхаар.

Д.Цогтбаатар: Тулга гишүүн түрүүн нэрээ өгөөд ороогүй юм байна лээ. Үг хэлчихье гэж байна. Тэгвэл гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Даваагийн Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Ямар ч байсан энэ нөгөө нэлээн залилангийн асуудал яригдаад байгаа асуудлыг цэгцлэх гээд явж байгаа Сайнзориг нарын гишүүд нэг зарчимтай хуулийн төсөл оруулаад ирж байгаад талархал илэрхийлье. Мөн энэ төрийн албан хаагч нартаа нэг бид нар нэг урам өгөөд хааяа ч гэсэн талархлаа илэрхийлчхэж байх хэрэгтэй байх аа. Одоо энэ орон сууцын залилан гээд л явахаар энэ Сайнжаргал хурандаа бол энэ Номинчимэг гишүүний Өргөдлийн байнгын хороон дээр байнга орж ирээд ажиллаад яваад байдаг. Тэгэхээр бас нэг энэ цагдаагийн байгууллага тэгээд тэр нөгөө болохгүй залилья гээд байгаа нөхдүүдийн өмнөөс энд тэнд очиж асуугдаад ажиллаад яваад байгаа төрийн албан хаагч нартаа бас талархал илэрхийлье. Одоо жишээлэхэд энэ хууль шийдэгдэх юм бол 204 орчим тэрбум төгрөгийн залилангийн асуудлыг ярьж байх шиг байна. Шийдчих юм шиг байгаа юм. Тэгэхдээ бас нэг санал болгоод хэлчих юмнууд нь жишээлэхэд энэ үл хөдлөх хөрөнгийн татвартай холбоотой асуудлыг яг Улаанбаатар хотод гэх юм уу, аймгуудад гэх юм уу тэрийгээ бас нэг тодорхой болгож өгвөл. Эсвэл тэр ҮТ дугаартай эсвэл ДТ дугаартай энэ гэрчилгээнүүд дээрээ банкны барьцаанд тавих процессынх нь асуудлууд ямархуу байдлаар шийдэгдэх вэ? Энийгээ бас нэг тодорхой болгоод явбал гэж.

Тэгээд нөгөө нэг компаниуд чинь бол барьж байгаа компаниуд дээрээ бас нэг татварынх нь хөнгөлөлт явагдах уу, үгүй юу гэдгээ нэг эсвэл компаниуддаа урам өгөх. Яг сайн бариад байгаа гэх юм уу, муу бариад байгаагууд дээрээ яах юм. Тэрийгээ бас нэг тодорхой яривал гэж байгаа юм. Уг нь бол энэ уул уурхайн компаниудад нөхөн сэргээлт хийх зардлыг урьдчилаад авдаг байдлаар хуулийн төсөл явж байгаа юм байна лээ. Яг тэрэн шиг энэ барилгын компаниудтай холбоотой асуудлуудыг 3 жил гэхгүйгээр тодорхой хэмжээний зардлыг урьдчилж аваад тэр барилга байшин нь шатдаг юм уу, ус алддаг юм уу айл өрхийн буруугаас болоогүй ийм асуудлууд зөндөө гараад байгаа юм. Жишээлэхэд манай энэ Чойжилсүрэн гишүүний компани нь бол маш олон байрыг энд тэнд маш их хэл ам дагуулаад хурдан барьдаг, ашиглалтад өгдөг, тэгээд 3 жилийн дараа шатдаг. Дөнгөж саяхан та бүхэн харсан байх. Энэ онцгой байдал тоног төхөөрөмж алга гээд л нэг бөөн юм болоод л гарсан. Цэнгэлдэх хотхон 23 давхарт нэг эх хүүхдээ цонхоороо бариад суучихсан байгаа шүү дээ. Аваръя аварч чаддаггүй. Тэгээд нөгөө материал нь тийм чанартай баригдсан эсэхийг нь мэдэхгүй. Сөх бол яах вэ дээ чааваас нэг муу орлого зарлага нь тэнцээд л зарим тохиолдолд өртэй явж байгаа. Гэх мэтчилнийхээ асуудлуудыг энэ барилгын компаниудаа сайжруулах талаас нь, хариуцлагажуулах талаас нь харах хэрэгтэй юм болов уу гэж харж байгаа гэдгээ энэчээ хэлэх гэсэн юм аа.

Д.Цогтбаатар: Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж үг хэлье ээ. Тэгээд өнөөдрөөс манай Номинчимэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд энэ орон сууцын захиалгатай холбоотой ямар нэгэн байдлаар нэг ухсан нүх нэг хэвлэсэн зураг үзүүлээд олон 100 иргэдийг залилчихсан хохироочихсон, шүүхийн маргаан үүсчихсэн дээр нь давхардуулж орон сууцыг зарсан гэсэн ийм зөрчлүүд 15, 16 төсөл

дээр илрээд өнөөдөр Улсын Их Хурал Өргөдлийн байнгын хороо авч хэлэлцээд энийг ингээд ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Энэ хохирогчдын хохирлын дүн бол нэлээн өндөр дүнтэй болсон. Бараг 200 гаран тэрбум төгрөгийн хохирлын асуудал яригдаж байгаа. Тэгээд энийг манай ажлын хэсэг өнөөдөр 3 салбарт хуваагаад ажил нь одоо бас яг цаашаа үргэлжлээд явах боломжтой төслүүдийг нь бас нэг явуулах талаар нь арга хэмжээ авах, огт ажил эхлээгүй байгаа мөн бүүр огт ямар ч найдваргүй болчихсон гэсэн ийм 3 хэсэгт хуваагаад ажлын хэсэг нэлээн идэвхтэй ажиллаад удахгүй бас Улсын Их Хурлын тогтоолыг оруулж ирнэ. Тэгээд яг цаг энэ цаг мөчид энэ манай Сайнзориг нарын гишүүдийн санаачилсан хууль орж ирж байгаа нь нэг талаараа дэмжихээс өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байгаа.

Тэгээд өнөөдөр энэ цаашлаад хаяг олгодог, энэ давхардуулж зардаг хоосон нэг ийм зураг үзүүлээд, нүх үзүүлээд, хундам үзүүлээд, нэг каркас үзүүлээд энэ орон сууцын захиалга авдаг ийм нөхцөл байдал бол бас энэ хууль батлагдсанаар зогсоно гэж харж байгаа.

Тийм учраас энэ иргэдийг цаашдаа хохироохгүй байхын тулд энэ хуулийн төслийг харин бид энэ хаврын чуулганаар хэлэлцэж зайлшгүй батлах шаардлагатай байгаа гэдгийг илэрхийлээд энэ хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж байна аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тулга гишүүний микрофоныг өгье.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амгаланг эрье ээ.

Тэгээд энэ хуулийг бол санаачлагчдын нэг. Энэ бол яах аргагүй цаг үеэ олсон. Ер нь энэ нийгэмд үүсээд байгаа энэ иргэдийн хоорондын харилцаа улсын бүртгэлтэй холбоотой энийг дагаад мөнгө санхүү, ингээд хууль хүчний байгууллага хүртэл ингээд оролцоод ирж байгаа энэ асуудал дээр бол яаралтай таслан зогсоож сэргийлэх арга хэмжээ авах ёстой. Ингэхдээ бол юу гэдэг юм хатуу хууль гаргаж хүчээр юу гэдэг юм аливаа юмыг иргэдийг гэдэг юм уу сонголтыг нь шахах гэхээсээ илүү мэдээлэлтэй болгох гэдэг өнцгөөсөө бол энэ маш сайн зөв боловсруул гэсэн ийм хуулиа гэж үзэж байгаа юм аа.

Тийм учраас та бүгдийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

Харамсалтай нь өнөөдрийг хүртэл зүгээр гарчихсан залилангийн гэдэг юм уу энэ үүсчихсэн хохирол энэ юунуудыг бол энэ хуулиар шийдэхгүй. Тэгэхээр энэ хүмүүсийн хэлж байгаа нэгэнт үүсчихсэн байгаа асуудлыг бол шийдэх тал дээр хэрхэн яаж ажиллах вэ гэдэг дээр бол яах аргагүй хууль хэрэгжүүлэх үүрэгтэй Засгийн газарт чиглэл өгөх ёстой.

Тийм учраас ХЗБХ-н даргад энэ Алтанхуяг дарга энэ тэрээс санал гаргачих шиг байна. Байнгын хороон дээрээ энэ асуудлыг Өргөдлийн байнгын хороотойгоо хамтардаг юм уу, авч үзээд нэгэнт үүсчихсэн ч бий болсон байгаа асуудал дээр эрх зүйн орчныг нь бас өшөө сайжруулах, магадгүй бас хохиролтой холбоотой энийг бол илүү хурдан шуурхай шийдвэрлэх гэдэг юм уу олж тогтоох ийм чиглэлийг Засгийн газарт өгөх нь зөв байх гэсэн ийм байр суурьтай байна аа.

Тийм учраас энэ хуулийг бол богино хугацаанд гишүүд маань дэмжээд яаралтай баталж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа.

Ер нь Монгол Улсад энэ орон сууц захиалгын залилан ихэвчлэн ямар хэлбэрээр яагаад яаж яваад байна, юунаас болоод байна гээд харах юм бол 1 дүгээрт барилгын зөвшөөрөл янз бүрийн газрын зөвшөөрөл нь байхгүй, техникийн нөхцөл авахгүй байж байгаад урьдчилгаа аваад удааширдаг асуудал байна.

Нэг байрыг олон хүнд худалдчихдаг, банканд барьцаанд тавьчихдаг асуудал байна. Компани өөрөө санхүүгийн чадавхгүй болоод зогсчихдог асуудал байна. Урьдчилгаа мөнгө авсан мөртөө тэрийгээ өөр төсөл рүү оруулчихдаг, өөр юманд зарцуулчихдаг, барилгадаа оруулдаггүй асуудал байгаа. Мэдээж худал мэдээлэл төөрөгдсөн сурталчилгаа хийж одоо ингэж иргэдийн тэр орон сууцтай больё гэсэн хүсэл мөрөөдөл дээр дөрөөлөөд ашиг олох гэсэн ийм ийм хэсэг бүлэг хүмүүс ингээд бий болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд энийг ингээд харах юм бол ерөөсөө энэ баригдаж дуусаагүй байгаа үед л хөрөнгө буюу орон сууцын асуудлын бүх эрсдэлийг санхүүгийн байна уу? Төрийн тэр дэд бүтэц техникийн нөхцөл их байна уу? Энэ бүх эрсдэлийг компанийн санхүүгийн ерөөсөө иргэдэд үүрүүлчхэж байгаа байхгүй юу. Эрсдэл хуваарилалтын онолоороо бид нар ерөөсөө зөвхөн иргэдэд энэ эрсдэлийг үүрүүлчхэж байгаа юм.

Тэгээд энэний шийдэл яг юу байх вэ гэх юм бол энэ эрсдэлийг л зөв хуваарилах эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил.

Тэгээд энэ эрсдэлийг зөв хуваарилах, тэнцвэржүүлэх ажил бол ерөөсөө түрүүний хэлсэн дундын хяналт байх ёстой. Тэрийг нь зарим улсад барилгын компани борлуулалт 2-ыг салгадаг үл хөдлөх агентаар хийдэг тэгж байж тэр агент өөрийн хариуцлагатай эрсдэлийг үнэлээд иргэдэд энэ байж болох юм байна мөнгийг чинь оруулж болж байна гэдэг. Үгүй бол 2 дахь нь бол банк санхүүгийн байгууллагаар дамжуулдаг. Банк санхүүгийн байгууллага угаасаа барилгын компанийг санхүүжүүлээд явахад иргэдийн мөнгийг аваад энэ дээр нь яг хяналт тавьж явдаг. Эсвэл эскро дансаар авдаг тийм үү. Эскро дансаар аваад яг энэ мөнгө нь тэр барилгадаа орж байна уу гэдгийг бол бид нар хянах боломжтой.

Тэгэхээр энэ мэтийн ийм санхүүгийн хөшүүрэг бол их хэрэгтэй байгаа. Тэгээд энэ хууль дээр яах вэ одоогоор ийм санхүүгийн хөшүүрэг дундын хяналтын асуудал орж ирээгүй байгаа.

Бид нар бол энэ Өргөдлийн байнгын хороо энэ асуудал дээр ажиллаад Барилгын яаманд ч, Хууль зүйн яаманд ч чиглэл өгсөн. Тэгээд одоогоор Барилгын яам Барилгын хуулийн шинэчилсэн найруулгыг оруулж ирнэ гэдэг юм хэлээд байгаа. Тэгээд энэ асуудлуудыг оруулж өгөөч гэдгийг бол хэлчхээд байгаа юм. Тэгэхээр тэр хууль ороод ирвэл уг нь бас ингээд бүхлээр нь хараад илүү сайн шийдэл болохоор байгаа. Сайнзориг нарын гишүүдийн оруулж ирж байгаа энэ хуулиар бол ядаж нэг байрыг олон хүнд ингээд давхар зарах асуудал бол илүү мэдээлэл нь ингээд бий болсноор байж болох юм. Тэгээд цаашид тэр Барилгын яамны тэр барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр ч гэсэн энэ нэг мэдээллийн сан иргэд өөрсдөө эрсдэлээс урьдчилан сэргийлээд мэдээллийг харах энэ санг бол арай илүү өргөн хүрээний байдлаар хийх ёстой байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ хууль мэдээж одоо цаашаа бид нар ямартай ч нэг барилгыг 3, 5 хүнд ингээд зэрэг зараад эсвэл банкны барьцаанд тавингаа зараад мөнгө авчихдаг байдлыг зогсоохын тулд бол явсан зураг. Гэхдээ яг гол шийдэл бол ерөөсөө л энэ дундын хяналтын асуудал байгаад байгаа юм. Тэрийгээ банк санхүүгийн байгууллага байх юм уу, үл хөдлөх хөрөнгийн агент байх юм уу эскро данс байх юм уу тэрийг бид нар Барилгын тэр хууль дээр илүү сайн тусгаж тал талаас нь хэлэлцээд энэ асуудлуудаа шийдэхгүй бол иргэдийнхээ энэ олон жил сайхан орон сууцад орчих юмсан гэсэн мөрөөдлийг ингээд байхгүй болгож байгаа асуудлыг л бол сайн шийдэх ёстой байгаа.

Тэгэхээр энэ хуулийг бол хэлэлцээд явах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүн микрофоныг нь өгье.

Д.Пүрэвдаваа: Би нэг ажлын хэсгийнхэнд нэг санал хэлэх гэсэн юм. Түрүүний та хэд маань үндсэндээ нэг сонссон байх. Ингээд 3 ангилж болж байна гээд, хууль санаачлагч Сайнзориг гишүүн хэллээ шүү дээ. Анхнаасаа бүүр ингээд гэмт хэргийн шинжтэй эхэлсэн төсөл. Замд нь бас нэг ийм төрийн хамааралтай тэр гэр хорооллын дахин төлөвлөлт ч гэдэг юм уу тэгээд ийм төслүүд нь бүтэлгүйтсэн асуудлууд байна. Төр оролцчихсон. Тэгээд нөгөө 3 дахь асуудал нь юу вэ гэхээр бизнесийн байгууллагууд эдийн засгийн нөхцөл байдлаасаа ч юм уу эсвэл дэд бүтцийн хүртээмжийн асуудлаасаа болоод гацалтад орчихсон зүйлүүд. Эдгээрийгээ та бүхэн маань тоон хэлбэрээр энэ Улсын Их Хурлын гишүүдэд аягүй зөв сайн хүргэх ёстой юм байгаа юм.

Тэгээд тэр нөлөөллийн судалгааг хийх ёстой. Тэр нь юу вэ гэхээр зэрэг захиалагч этгээд бол хууль зүйн мэдлэггүй, эдийн засгийн мэдлэггүй санхүүгийн. Гэтэл нөгөө борлуулагч тал бол тэр бүх зүйлээр хангагдах боломжтой. Тэгэхээр энэ уялдаа холбоо зүйлүүдээ маш сайн тодорхой гаргаж ирээд тэгээд төрийн оролцоог минимумд хүргэх хэрэгтэй. Тэгэхгүй бүртгэлд бүртгэж байна гээд тэгээд жилд хэдэн мянган иргэн захиалга өгдөг юм, больдог юм, цуцалдаг юм, тэгээд хувь хүний нууцын асуудал яригдана. Тэгээд манай улсын бүртгэлийн газар бол хүмүүсийн төрсний гэрчилгээг хүртэл нэр усыг нь зөв бичиж чадахаа больчихсон юм шүү дээ. Дандаа алдаатай. Тэгээд юмнууд нь зөрөөд явчихдаг. Тэгээд энэ бүх юм чинь тэгээд аягүй тэгээд тийм учраас энэ бүртгэлийн байгууллагад эрх үүрэг ноогдуулж байгаа бол ялангуяа хариуцлагын асуудлыг нь аягүй сайн тодорхойлж өгөөрэй.

Тэгэхгүй тэгээд л өөрсдөө хүндрүүлдэг тэгээд л ер нь л та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Улсын комисс ажилд авна гэдэг чинь одоо нэг хуримын ширээ засаж байгаа юм шиг л энэ барилгын компаниуд юм болдог шүү дээ. Тэгээд л нөгөө комисс нь ирж байна гээд л бөөн найр наадам. Тэгээд нэмэгдээд бүртгэл гэдэг нэг ийм тусдаа нэг үе шат нэмэгдэх нь байна зөв үү? Тэгэхээр ийм зүйлүүдээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй шүү. Та бүхэн маань ард түмэндээ хууль баталж байгаа бол нэг зүйлийг нөгөө талд нь харуулах хэрэгтэй. Бид ямар нэгэн чирэгдэл үүсгэхгүй гэдгээ нотлох ёстой. Тэгж байж хүмүүсийн дэмжлэг авна. Тэгэхгүй бол дахиад л 1 үе шат нэмэгдэх тоолонд л эхний ээлжид бол дахиад л нэг төвөгтэй асуудал үүслээ л гэж хардана.

Тэгэхээр зэрэг хууль санаачлагч нарт юу хийх ёстой вэ гэхээр зэрэг бид улам л иргэн талдаа сайн сайхан зүйлийг хийх гэж байна. Гэхдээ төрийн хүнд суртал энэн дээр бол 0 нөлөөлөлтэй байна гэдгээ л харуулах хэрэгтэй. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Би товчхон хэлчихье ээ. Ер нь энэ газар нь ч маргаантай хөрөнгө оруулагч нь ч маргаантай амьтад мөнгө цуглуулдгийг л зогсоох ёстой юм. Энэ хууль дээр. Тэр нь юу гэсэн үг вэ гэхлээр тэр барьж байгаа орон сууцын чинь ядаж нэг хэд юм би мэдэхгүй байна л даа. 30-аас 40 хувь нь ядаж шовойсон байх хэрэгтэй. Огт шовойгоогүй юман дээр одоо энэ ард иргэдийн мөнгийг авч ингэж нураана гэдэг бол бид нар харсаар байгаад л тэд нар тэрийг бол ёстой хүнд байдалд оруулаад байгаа юм байна лээ. Нөгөөх нь бол зарцуулалтыг заавал ингээд шат шатаар гээд байхгүй. Энийг тэгэхгүй бол хамаг мөнгөө өгөөд л тэгээд 10 жил хүлээнэ гэдэг дуусчхаад байгаа юм. Тэгэхээр энэ төр гэж байдаг засаг төр гэж байдаг. Зохицуулалт хийнэ гэдэг бол заавал оролцох ёстой шүү л гэж би нэг ийм санаа хэлэх гээд байгаа юм. Тэр нь тэгэхдээ төрийн хүнд суртал бий болгоно гэсэн үг биш. Одоо энэ Римакс гэдэг нөхдүүд чинь тэрэнд ажиллаж байгаа нөхдүүд агентууд нь мөнгөө олоод л тийм нормалный ажиллаад л байна шүү дээ. Тэгээд 1 ийм зах зээлийн маягийн аятайхан систем олчихье л доо. Тэгээд тэр бүртгэл нь явна биз.

Сайнзориг гишүүн та харин энэ хууль дээр тэр нэг өөр хөнгөлөлт чөлөөлөлт тийм юм ярихгүй шүү. Одоо энэ бүртгэл орж байгаа ч гэсэн тэр их өөр асуудал шүү дээ. Би зүгээр ташрамд хэлчихье. Тэгэхээр энийгээ ингээд нэг жаахан зөв болгоод явуулчихмаар байна. Тэгээд намар гэхэд нэг энэ иргэдийн эрх ашгийг хамгаалсан энэнээс хойш түүнээс цааш иргэд нэг 5 төгрөг олоод орон сууц босгоно гэж өгчхөөд одоо ингээд юу ч үгүй сууж байна гэсэн нэг ийм асуудлыг л бид нар нэг зогсоомоор байна. Энэ Их Хурал хамтраад хэдүүлээ. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Би нэг хэдэн үг хэлээдэхье.

Энэ хуулийг би өөрөө зурж дэмжиж санаачлалцаж явж байгаа. Тийм учраас би өөрөө дэмжиж байгаа. Зүгээр энэ дээр нэг хэдэн санаа хэлчихмээр байна. 2015 онд би өөрөө Барилгын сайд байсан. Яг энэ бүх асуудлуудыг ёстой хөндөж тавиад зүтгүүлээд яваад тэгээд манай Засгийн газар буусны дараа энэ ингээд зогсчихсон. Ингээд аж үйлдвэр ер нь ийм том үйлдвэрлэл бүтээн байгуулалтын салбарын юм нэг зогсчихлоороо та бүгд харж байгаа биз буцаад орж ирэх гэж 11 жил энэ хугацаанд хэчнээн олон хүний эрх ашиг ард нь хохироод явж байгаа вэ. Тэгэхээр хууль тогтоогчдын тухайн үедээ ярьж байсан асуудлаа яригдаж байгаа, мэдрэгдэж байгаа тэр улс төрийн нөхцөл нь бүрдсэн үедээ л хийхгүй бол дараа нь гацаад өөр өөр асуудлуудад ингээд л төөрөөд явчихна. Уг нь энэ асуудлыг салбар нь өөрөө оруулж ирэх ёстой байхгүй юу. Яагаад гэвэл та нарын бүгдийн асуугаад байгаа асуултууд аягүй логиктой зөв асуултууд байгаад байгаа юм. Пүрэвдаваа гишүүний асууж байгаа юм энд ингээд яригдаж байхад нэг өнцгөөр манайхан Сайнзориг гишүүн хэдүүлээ ч гэсэн энийг оруулаад явахдаа энэ чинь барилгын салбарынхны нэр төрийн эсрэг хууль ерөөсөө биш шүү. Энэ чинь сайн ажиллаж байгаа барилгын компаниудыг хамгаалах гээд байгаа байхгүй юу? Тэд нарын сайн нэрээр би чадна бригад орж ирээд хэдэн төгрөг хийгээд хүмүүст барилгаа барьж өгөхгүй бултаад хэчнээн хүнийг насных нь хуримтлалаар хохироогоод байгаа тухай асуудал яригдаж байгаа юм.

Эсрэгээрээ ийм юм байхгүй болох юм бол барилгын салбарын нэр хүнд улам өснө гэсэн үг. Тэгэхээр энэ барилгын салбарыг энэ тал дээр нь зөв талаас нь ойлгуулж ярихгүй бол нөгөө хүмүүс чинь барилгынхаа ерөөсөө хүмүүсийг хуураад байгаа юм байна гэдэг. Ингэх юм бол энэ чинь буруу тал руугаа энэ нөгөө энэ хуулийн зорилго ерөөсөө эхнээсээ тийм биш. Энэ дээр тэр яах аргагүй ийм хуулийн оролцоо орж ирэхгүй бол энэ эрх зүйн харьцааны нэг онцлог байгаа юм. Нөгөө мэдээллийн асиметри гэж. Барилгын компани нь бүх юмаа мэдэж байгаа юм. Авах гэж байгаа хүн тэр барилгын компанийн мэдэж байгаа мэдээлэлтэй хэзээ ч байдаггүй. Жишээлбэл газрын өмч нь яг бодитой үнэн үү? Газар төлөвлөлт нь үзүүлэхээр энэ түрүүн Одонтуяа гишүүн хэлж байна лээ. Нэг их гоё юм үзүүлчихдэг тэгсэн нээрээ ингээд зургаараа яг л тийм байгаа байхгүй юу. Тэгсэн 2 сарын дараа нөгөө яг цонхыг нь хаагаад өөр байшин барьчихыг нөгөө барьж байгаа компани бол өөрийнхөө худлаа яриагүй тэр чинь. Яг үнэнээ яриад энд би барих гэж байгаа юм уу гэсэн цонхыг нь хаагаад өөр барилга барихыг тэр хүн хянаж мэдэхгүй. Хотын захиргаан дээр тэр шийдэгдчихэж байгаа байхгүй юу. Ингэнгүүт тэр худалдан авч байгаа хүн бол хэзээ ч гүйцэд мэдээлэлтэй байж гүйцэж чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэн дээр тэрийг хариуцлагажуулж өгч энэ мэдээллээ барьж байгаа компани өөрөө гүйцэд хариуцлагаа хүлээж яагаад гэвэл хүнд зарж байгаа юм чинь зөвхөн тэр цемент биш нөгөө тохь тух тохижилт энэ юм нь хамт үнэд нь тусчхаад байгаа болохлоор энэ гэрээний салшгүй хэсэг мөн байхгүй юу. Энийг нь заавал оруулж өгдөг болж энд нөгөө төр хохирч байгаа эрхийг нь нөхөж өгч оруулж өгөхгүй бол энд хэзээ ч тэгш эрхтэй харилцаа бүрдэхгүй байгаад байгаа юм. Тэр үүднээсээ энэ харилцаа заавал орж ирж зохицуулалт орох нь зөв өө гэж үзэж байгаа. Тэр үүднээсээ бол бас дэмжиж байгаа юм аа. Тэгээд энэ энэ хуулийг ингээд оруулаад ирснийг хэдүүлээ барилгын салбартайгаа хэлэлцэх явцдаа харин нэлээн сайн хэлэлцээд энэндээ тэр орох хүмүүсийг нь жишээлбэл Пүрэвдаваа гишүүн эд нарыг оруулаад энийгээ сайн хэлэлцээд явах нь зөв өө гэж бодож байна.

Тийм яах вэ асуудлаа түрүүн нэлээн зөв өнцгөөс нь ярьж байна лээ. Үгүй үгүй үгүй хэн нь орох нь хамаагүй. Тэгэхдээ би нөгөө салбарын төлөөлөл нь зөв ороосой л гэж ярьж байгаа юм аа. Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтдаа гишүүд бэлдье.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт

54.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан:

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ

3.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

За 58.3 хувиар санал дэмжигдлээ.

4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

5.Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор Санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хөөе энэ хэн Алтангэрэл гишүүн ээ. Баасанжаргал гишүүн горимын санал гаргая.

Х.Баасанжаргал: Төхөөрөмж ажилласангүй тэгээд горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн Баасанжаргал гишүүний горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд түрүүн уншиж танилцуулсан. Уншсан томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

6.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

7.Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

8.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

9.Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдаваа гишүүн танилцуулчих уу?

Ажлын хэсэгт баярлалаа.

16.02 цаг

Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Энд нэлээн хэдэн санал байгаа шүү гишүүд ээ. 8 санал хураана. Гэхдээ асуудал нь саяынх шиг биш. Гишүүд жоохон суугаад хэдүүлээ ажлаа дуусгачихъя. Одоо энэ 3 дугаар асуудал. Би тогтоолын төслөө танилцуулаадахъя уншъя.

Гишүүдэд тараасан байгаа тогтоолын төслийг.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол 2026 оны ... дугаар сарын ... дугаар өдөр дугаар... Улаанбаатар хот

“Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн ХЗБХ-оос тогтоох нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Баярбаатар Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд О.Номинчимэг Улсын Их Хурлын гишүүн, Х.Баасанжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, П.Сайнзориг Улсын Их Их Хурлын гишүүн, С.Эрдэнэболд Монгол Улсын Их Хурлын гишүүн, С.Одонтуяа Монгол Улсын Их Хурлын гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг Ажлын хэсэг Баярбаатарт зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хороо Цогтбаатар гэсэн байна.

Тэгье Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Энэ их чухал хууль байгаа. Хуулийг ер нь намрын чуулганаар хэлэлцүүлж батлах ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Улсын Их Хурлын даргын захирамж бол гарахгүйгээр Байнгын хороон дээр ингээд ажлын хэсэг байгуулаад ажиллая гэдгээр тогтсон. Одонтуяа гишүүн бол ажлын хэсгийн дэд ахлагчаар ажиллах саналыг ирүүлсэн боловч Байнгын хорооны тогтоолоор гарч байгаа учраас ажлын хэсгийн гишүүн гэдгээр яваад, дээр нь Алтангэрэл гишүүнийг ажлын хэсэгт нэмэх саналтай байна аа. Тийм учраас ингээд Алтангэрэл гишүүнийг нэмээд нийтдээ 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулах саналыг гаргаж байна. Дэмжиж өгнө үү.

Д.Цогтбаатар: Тэгвэл би түрүүн юуг нь тогтоолын төслийг уншаад танилцуулчихсан байгаа. Ажлын хэсэг дээр Одонтуяа гишүүнийг, Алтангэрэл гишүүнийг нэмж оруулаад энэ тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Эхлээд санал хураалтдаа бэлдье. Гишүүд ээ санал хураалтдаа дахиад нэг бэлдчихье. Санал хураалтдаа бэлдье.

Сая уншиж танилцуулсан. Тэгээд тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

54.2 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

16.08 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Дөрөвдүгээр асуудал ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлъе.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүгдэд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол 2026 оны ... дугаар сарын дугаар ... өдөр, дугаар Улаанбаатар хот. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн ХЗБХ-оос тогтоох нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүнээс 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Х.Баасанжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд П.Сайнзориг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Х.Тэмүүжин Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг Ажлын хэсэг Х.Баасанжаргалд зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн байна аа.

Ингээд энэтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Тэгвэл энэ саяын уншиж танилцуулсан томъёоллоор тогтоолыг дэмжъе гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

16.10 цаг

Тав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Тавдугаар асуудал “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүгдэд уншиж танилцуулъя.

Нэгмөсөн уншаад явчихъя даа.

Эс үгүй бол ер нь тогтоолын төслүүд бүгд адилхан шүү дээ. Тийм учраас би шууд ажлынхаа хэсгийн бүрэлдэхүүнийг уншаад явчихъя тэгэх үү? Тэгье тэгье. Тэгвэл Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн тухай асуудал байгаа. Ажлын хэсгийн ахлагч. Задгай байна хэн хэн орох вэ? Ер нь.

Тэгвэл ингээд ажлын хэсгийн ахлагч Алтангэрэл гишүүн, тэгээд ажлын хэсэгт Пүрэвдаваа гишүүн, өөр саналаараа орчих гишүүн хэн байна? Цэнгүүн гишүүн саналаараа орчих уу? Хууль тогтоомжийн тухай хууль. Цэнгүүн гишүүн ажлын хэсэгт. Тэгвэл ингээд ажлын хэсгийн ахлагч Алтангэрэл гишүүн, ажлын хэсгийн гишүүд, Пүрэвдаваа гишүүн, Цэнгүүн гишүүн гэсэн ийм юугаар бүрэлдэхүүнтэйгээр тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

16.14 цаг

Зургаа. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

“Тогтоолын тогтоол өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүгдэд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол 2026 оны ... дугаар өдрийн ... дугаар өдөр. Дугаар. Улаанбаатар хот.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн ХЗБХ-оос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их

Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн Алдаржавхлан, Сандаг-Очир нарыг тус тус хассугай. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн байна аа. Энэ томьёоллоор санал хураалт явуулъя. Энэ тогтоолыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

16.14 цаг

Долоо.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Долоо Цаглавар батлах тухай

Гишүүд цаглаварыг та бүгдэд тараасан байгаа. энүүгээр асуух асуулттай гишүүд. Байна уу? тэгвэл цаглаварыг шууд баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

8 дугаар асуудал. Дараагийн асуудалдаа оръё.

16.16 цаг

Найм.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай санал /Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн 2026.05.21-ний өдөр Улсын Их Хурлын даргад ирүүлсэн/

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэнгээс 2026 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсын Их Хурлын даргад ҮХЦ-д хүсэлт гаргах тухай саналыг өргөн мэдүүлсэн байна.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүний саналыг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1 дэх заалт нь Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчиж буй асуудлаар Цэцэд дараах хүсэлтийг гаргаж байна аа.

Үүнд:

1.Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн нэг дэх заалтад Монгол Улсын төсвийн хэрэгжих хугацааг тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгож нэг жил байхаар хуульчилж өгсөн байна аа.

Мөн Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь заалтад хөрөнгө оруулалтын арга хэмжээг 3 жилд багтаан санхүүжүүлэхээр заасан байна аа. Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байдаг.

Гэтэл Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2, 13.1.3, 13.1.4 дэх заалтуудаар батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 5 дугаар сарын 31-ний дотор зохион байгуулах, зохион байгуулж амжаагүй бол төсөл арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцож төлөвлөгдсөн санхүүжилтийг буцаан татаж зогсоохоор заасан нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 29 дүгээр зүйлийн 3.5 дахь заалтуудыг зөрчин хэрэгжих хуулийн хугацааг хязгаарлах нөхцөл байдлыг үүсгэж төсвийн ихээхэн хөрөнгө ашиглагдахгүй Төсвийн тухай хууль зөрчигдөх нөхцөл байдлыг үүсгэж байна.

2.Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйл 45 дугаар зүйлд төсвийн зарла зар зарлагын хэмнэлтийг зохицуулахаар заасантай төрийн хэмнэлтийн хуулийн 13.1 дэх заалтууд нь зөрчилдөж байна аа. Иймд мөн Улсын Их Хурлын гишүүн миний бие төрийн хэмнэлтийн хуулийн 13.1 дэх заалт нь Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчиж буй асуудлаар Цэцэд хүсэлт гаргаж байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлж ҮХЦ-д уламжилж өгөхийг Танаас хүсье.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн гэсэн байна.

Ингээд та бүгдэд саналыг танилцууллаа? Санал гаргасан гишүүн байхгүй байгаа тул шууд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя аа. Байхгүй байна гишүүд одоо санал хураалтдаа бэлдье.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчиж байгаа талаар Улсын Их Хурлаас ҮХЦ-д хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүний саналыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар гишүүн танилцуулчих тэгэх үү? Цогтбаатар гишүүн танилцуулна аа.

16.20 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Ес. “Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Сүүлийн ганц асуудал үлдсэн. Бусдаас асуудлын хүрээнд Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар нарын 30 гишүүнээс Монгол Улсын Их Хурлын даргад хандан 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Ерөнхий хяналтын сонсгол явуулах тухай хүсэлт гаргасны дагуу хэлэлцэж байна аа.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

2026 оны ... дугаар өдрийн ... дугаар сар. Дугаар. Улаанбаатар хот.

“Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.1 дэх заалт, 121.1.1, 121.3 дахь хэсэг, 122.1 дэх хэсэг, Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь хэсэг. Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

Ерөнхий хяналтын сонсголыг гадаад улсын зарим иргэний холбогдсон гэмт хэрэгт Монгол Улсын талаар дурдагдсан асуудлын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах сэдвээр 2026 оны 10 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Гадаад улсын зарим иргэний холбогдсон гэмт хэрэгт Монгол Улсын талаар дурдагдсан асуудлын хүрээнд, хүний эрх, эрх чөлөөг хангах асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол, даргалагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарыг сонгосугай.

3.Ерөнхий хяналтын сонсголын зарыг нийтэд мэдээлж бэлтгэл ажлыг ханган холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасугай.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн ийм тогтоолын төсөл байна аа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдон асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье. Алга байна. Тэгвэл гишүүд одоо санал хураалтдаа бэлтгэе.

Сая энэ дээр үг хэлэх боломж байсан юм байна. Тэгвэл үг хэлэх гишүүн байхгүй байна. Энэ дээр нөгөө сонсгол даргалагчийг тусдаа сонгох юм байна. Тийм учраас сонсгол даргалагчийг сонгох санал хураалт явуулна. Ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг сонгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

54.2 хувиар санал дэмжигдлээ.

Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

54.2 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Гишүүддээ талархал илэрхийлж байна.

16.24 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА